

**“Санхүүгийн зохицуулах
хорооны зохицуулалтын салбар
дахь компайнсын эрсдэлийн
үнэлгээний аргачлал
боловсруулах”
судалгааны зөвлөх ажлын
тайлан**

СЭЗИС-ийн судалгааны баг

2023 он

АГУУЛГА

АГУУЛГА.....	2
УДИРТГАЛ.....	4
БҮЛЭГ 1: КОМПАЙНСЫН ОНОЛ АРГА ЗҮЙ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА	5
1.1 Компайнсын онол арга зүй, хөгжлийн чиг хандлага	5
1.2 Компайнсын хамрах хүрээ, чиг үүрэг.....	6
1.3 Компайнсын удирдлага, оролцогч талууд	8
1.4 Компайнсын чиг хандлага	9
Бүлгийн дүгнэлт.....	10
БҮЛЭГ 2: ОЛОН УЛСЫН ТҮВШИНД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН КОМПАЙНСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	11
2.1 Санхүүгийн зах зээлийн компайнсын эрх зүйн зохицуулалтын тэргүүн туршлага	13
2.2 Санхүүгийн байгууллага бүрийн түвшний компайнсын зохицуулалт.....	16
2.3 Монгол Улсын санхүүгийн салбарын компайнсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал	18
Бүлгийн дүгнэлт.....	24
БҮЛЭГ 3: СЗХ-НЫ ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАР ДАХЬ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН КОМПАЙНСЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ НЬ	27
3.1 Санхүүгийн байгууллагын компайнсын тогтолцооны өнөөгийн байдлын судалгаа	27
3.2 Судалгааны үр дүн.....	28
БҮЛЭГ 4: КОМПАЙНСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ НЬ	30
4.1 Компайнсын эрсдэлийн үнэлгээний аргачлалын онолын судалгаа.....	30
4.2 Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбар дахь компайнсын эрсдэлийн үнэлгээний аргачлал	42
Бүлгийн дүгнэлт.....	51
ДҮГНЭЛТ	53
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	55
ХАВСРАЛТ	57
НОМ ЗҮЙ	68

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.1 Комплаинсын үүрэг ба өөрчлөлтүүд.....	7
Хүснэгт 1.2 Комплаинсын удирдлага ба оролцогч талууд.....	8
Хүснэгт 2.1 Санхүүгийн зах зээлийн хөгжлийн индекс	11
Хүснэгт 2.2 Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хуулийн харьцуулалт	19
Хүснэгт 2.3 Даатгалын үйл ажиллагааны зохицуулалтын хуулийн харьцуулалт.....	20
Хүснэгт 2.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн харьцуулалт.....	21
Хүснэгт 2.5 Хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалтын хуулийн харьцуулалт	22
Хүснэгт 4.1 Уламжлалт эрсдэл тооцох матриц.....	36
Хүснэгт 4.2 Үлдэгдэл эрсдэл тооцох матриц.....	37
Хүснэгт 4.3 Нийт эрсдэл тооцох матриц.....	37
Хүснэгт 4.4 Эрсдэлийн төрөл	46
Хүснэгт 4.5 Комплаинсын эрсдэлийн үр нөлөөний шалгуур.....	48
Хүснэгт 4.6 Эрсдэлийн матриц	49
Хүснэгт 4.7 Эрсдэлийн түвшин	49
Хүснэгт 4.8 Асуултын нэгтгэл хийсэн тооцоолол.....	50
Хүснэгт 4.9 Бүлгийн нэгтгэл хийсэн тооцоолол	50

Зургийн жагсаалт

Зураг 1.1 Комплаинс гэж юу вэ?.....	5
Зураг 1.2 Комплаинсын эрсдэлийн хүчин зүйлс.....	6
Зураг 1.3 Комплаинсын хамрах хүрээ	6
Зураг 1.4 Комплаинсын үүрэг	7
Зураг 1.5 Комплаинсын 2023 оны тэргүүлэх 10 удирдлага	8
Зураг 1.6 Комплаинсын зохицуулалтын өөрчлөлт	9
Зураг 2.1 Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын баримт бичгүүд	12
Зураг 2.2 Комплаинсын бүрэлдэхүүн хэсэг.....	15
Зураг 2.3 Комплаинсын 3 түвшиний зохицуулалтын орчин	16
Зураг 2.4 Монгол Улсын санхүүгийн салбарын зохицуулалтын хуулиуд	18
Зураг 3.1 Судалгааны хамрах хүрээ.....	27
Зураг 4.1 Комплаинсын эрсдэлийн үнэлгээ.....	31
Зураг 4.2 Комплаинсын эрсдэлийн удирдлага	31
Зураг 4.3 Комплаинсын хамрах хүрээ	31
Зураг 4.4 Комплаинсын эрсдэлийн систем.....	39

УДИРТГАЛ

Санхүүгийн салбар дахь тогтвортой байдлыг хангахын тулд засаглал, эрсдэлийн удирдлагаас гадна комплаинсын удирдлагыг хэрэгжүүлэх олон улсын тэргүүн туршлага байна. Сүүлийн жилүүдэд арилжааны банк, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ-ын бүтээгдэхүүн үйлчилгээг ашиглах замаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өссөн ба мөнгө угаалт, терроризмыг санхүүжүүлэх (цаашид МУТС гэх) эрсдэлийг улсын хэмжээнд үнэлж, хянах зайлшгүй шаардлагатай болсон байна. Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага болох ФАТФ-ын 40+9 зөвлөмжийг улс орнуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх хэрэгтэй байна. МУТС-тэй тэмцэх, санхүүгийн хориг тавих эрх бүхий олон улсын хэд хэдэн байгууллага байдаг бөгөөд манай улсын хувьд гишүүн орноор элсэн, дүрэм журмыг нь дагаж мөрдөх үүрэгтэй байгууллага нь ФАТФ юм. Монгол банкны санхүүгийн мэдээллийн алба нь ФАТФ-ын 40 зөвлөмжийн дагуу үндэсний харилцан эрсдэлийн үнэлгээ хийсэн бөгөөд тайлангийн үр дүнгээс харахад санхүүгийн системийн дийлэнх хувийг эзэлж буй банкны, банкны бус салбарын хувьд харилцагчийг таних, эцсийн өмчлөгчийг тогтоох үйл ажиллагааг нэн даруй сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна. Банкууд төдийгүй бусад санхүүгийн байгууллагууд энэ төрлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх комплаинсын удирдлагыг тогтолцоог бүрдүүлэх, түүнийг тасралтгүй сайжруулах нь тухайн байгууллагыг төдийгүй улс орныг эрсдэлээс хамгаалах гол арга хэрэгсэл болно. Хөрөнгийн хэмжээ их арилжааны банкуудад комплаинс хариуцсан алба, нэгж, ажилтан, хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө байдаг бол банкаас бусад санхүүгийн байгууллагуудад комплаинсын тогтолцоо харилцан адилгүй байна.

Комплаинс нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрсдэлийг урьдчилан хамгаалах үйл ажиллагаа бөгөөд байгууллагын эрсдэлийн удирдлага ба дотоод хяналтын үйл явцыг үнэлэх ба сайжруулахад тусалдаг.

Судалгааны зорилго: Комплаинсын эрсдэлийн үнэлгээ хийх арга зүйг боловсруулж, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамрагдаж буй салбарын байгууллагуудын хүрээнд комплаинсын эрсдэлийн өнөөгийн байдлын судалгаа хийж, комплаинсын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж боловсруулахад судалгааны ажлын зорилго оршино.

Манай улсын хувьд мөнгө угаах чиглэлээр олон судалгааны ажил хийгдэж байсан боловч илүү өргөн хүрээгээр буюу комплаинсын чиглэлийн судалгаа харьцангуй дутмаг хийгджээ. Энэхүү судалгаа нь манай улсын Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбар дахь комплаинсын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, цаашид салбарын хэмжээнд тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлсон анхны судалгаа гэдгээрээ онцлог юм. Энд комплаинсын удирдлагын орчин үеийн чиг хандлага, Монгол улс дахь эрх зүйн орчин, салбарын комплаинсын өнөөгийн байдал, комплаинсын эрсдэлийн үнэлгээний аргачлал боловсруулах гэсэн үндсэн 4 бүлэгтэй. Судалгаанд СЗХ-ны зохицуулалтын салбарт харьяалагдах итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ, Хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК), Даатгагч, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (цаашид ВХҮҮ гэх) гэсэн байгууллагууд хамрагдсан болно.

БҮЛЭГ 1: КОМПЛАЙНСЫН ОНОЛ АРГА ЗҮЙ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

1.1 Комплайнсын онол арга зүй, хөгжлийн чиг хандлага

Комплайнс гэдэг нь бодлого заавар, дүрэм журам, зохицуулалтын дагуу ажиллах чадварыг тодорхойлно. Комплайнс гэж “үйл ажиллагаандаа хууль тогтоомжийг дагаж мөрдөх, ажил үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн стандартыг баримтлах, гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, компанийн засаглалын нэгэн хэсэг бөгөөд тухайн байгууллага хууль тогтоомж, журам, зааварт нийцүүлэн ил тодоор үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг илэрхийлэх чадамж” юм. Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хувьд комплайнс нь хоёр түвшинд хэрэгжинэ.

Зураг 0.1 Комплайнс гэж юу вэ?



Эх сурвалж: <https://www.thomasnet.com/insights/how-to-create-an-effective-product-compliance-program/>

АНУ-ын мужуудад комплайнс нь 1960-аад оноос эхлэн хөгжиж ирсэн ба гол хүчин зүйл нь хууль тогтоомж, дотоод хяналтын удирдамжийн дагуу хэрэгжилтийг хангах зорилготой комплайнсын нэгж, ажилтан бэлдэхийг шаардаж эхэлсэн байна. 1960 - 1990 оны хооронд хар тамхины эсрэг АНУ хэмжээнд хөдөлгөөн өрнөж, авлигын эсрэг шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр 100 гаруй томоохон байгууллагыг оролцуулаад 400 гаруй байгууллагын авлигын хэргийг ил тод болгож чаджээ.

Комплайнсын тогтолцоог байгууллагын бүх түвшинд төлөвшүүлэх шаардлагатай ба үйл ажиллагааны бүх шатанд эрсдэл үүсэх аюултай байдаг. Олон улсын шүүх тогтолцоо нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд комплайнсын дүрэм журамд үндэслэн ял шийтгэл торгууль оногдуулна. Тиймээс шударга байдал, үр дүнтэй комплайнс нь тасралтгүй сайн менежментийн гол хүчин зүйл юм. Байгууллагын комплайнсын удирдлага нь үнэт зүйлс, сайн засаглал, ёс зүй, стандарт гэх бүрэлдэхүүнтэй байна. Байгууллагын ажилтнууд комплайнсыг хэрэгжүүлэх нь манлайлал, үнэт зүйлс, комплайнсыг дүрэм журмыг хүлээн зөвшөөрөх юм. Комплайнс нь байгууллагын амжилттай, тогтвортой өсөж хөгжихийн үндэс суурь, боломж ба энэ нь тасралтгүй үйл явц байдаг, байгууллага үүргээ биелүүлж байгаа гол үр дүн ба байгууллагын соёл, ажилтнуудын зан төлөв, хандлагад нөлөөлөх замаар тогтвортой хэвшүүлж байдаг. Урт хугацаанд амжилтад хүрэхийг зорьж буй байгууллагууд сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлтийг харгалзан комплайнсын соёлыг бий болгож, хэв маяг бүрдүүлэх нь чухал юм. Байгууллагын үр дүнтэй комплайнсын тогтолцоо нь холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын шаардлага, салбарын дүрэм, байгууллагын дотоод стандарт, сайн засаглалын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг туршлага, ёс зүйтэй байх илэрхийлэл ба нийгмийн хариуцлагын төлөвшилд чухал хувь нэмэр оруулдаг юм. (ISO 37301, 2021)

Зураг 0.2 Комплайнсын эрсдэлийн хүчин зүйлс



Эх сурвалж: (Understanding compliance risk in Finance and Banking, 2019)

Хараат бус байдлаа хадгалах ба комплайнсын удирдлагыг байгууллагын бусад удирдлагын үйл явц, үйл ажиллагааны шаардлага, журамтай нэгтгэх нь маш үр дүнтэй байдаг. Ялгаатай өөр төрлийн их өгөгдлийн сан нь эрсдэлийг удирдах шинэ арга, эрсдэлтэй үйл ажиллагааг урьдчилан таамаглах боломжтой болгоно.

1.2 Комплайнсын хамрах хүрээ, чиг үүрэг

Байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. а) тасралтгүй комплайнсыг хангахын тулд шинэ болон өөрчлөгдсөн комплайнсын үүргийг тодорхойлох; б) тодорхойлсон өөрчлөлтүүдийн нөлөөллийг үнэлж, комплайнсын удирдлагад шаардлагатай өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх. Байгууллага нь комплайнсын үүргийнхээ талаар баримтжуулсан мэдээллийн санг хөтөлж бүртгэнэ. Комплайнсын үүрэг нь аливаа байгууллагын эрсдэлийн тогтолцооны гол бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ нь бизнест тулгарч буй зохицуулалтын эрсдэлийн талаар удирдлагатаа мэдээлэх үүрэг гүйцэтгэдэг бөгөөд зохих хяналтыг тодорхойлон зөвлөгөө боловсруулна. Зохицуулагч байгууллагатай харилцах, мэдээлэх үүргээ биелүүлэх, зохицуулалт хийх үйл ажиллагаа, болзошгүй зөрчлийг арилгах болно.. Гэсэн хэдий ч энэ нь комплайнсын оролцогч талуудын өргөн хүрээний шаардлага, өндөр хүлээлтийг бий болгох магадлалтай ба өгөгдөл, технологийн дэвшилтэй нэмэгдүүлэхийн тулд шинэ ур чадвар шаардлагатай болж байна. Уламжлалт хамгаалалтын гурван шугамын загварт бий болсон өөрчлөлттэй хослуулан сорилт, боломжуудын аль алиныг нь дагаж мөрдөх шаардлагатай. (Basel Committee on Banking Supervision, 2020)

Зураг 0.3 Комплайнсын хамрах хүрээ



Эх сурвалж: (The Scope and Evolution of Compliance, 2018)

Комплайнсын үүрэг

Уламжлалт "комплайнсын хамрах хүрэн" дэх гол бүрэлдэхүүн хэсгүүдийг доорх зурагт харуулав. Эдгээрийг салбарын оролцогч талууд болон зохицуулагч байгууллага аль аль нь дагаж мөрдөх ёстой байдаг. (Association for Financial Markets in Europe, 2018)

Хүснэгт 0.1 Комплайнсын үүрэг ба өөрчлөлтүүд

Комплайнсын үүргүүд	Өөрчлөлтүүд	Комплайнсын чиг хандлага
<p>Зохицуулалтын хөгжил - Өөрчлөлтийг танин мэдүүлэх, бизнесийн зөвлөгөө өгөх</p> <p>Эрсдэлийн үнэлгээ - Дүрэм журмын эрсдэлийг үнэлэх, арга зүйн загварчлал бий болгох</p> <p>Комплайнсын бодлого стандартууд - стандартуудын загварчлал, сургалт хийх</p> <p>Хяналт зөвлөгөө - шинээр бизнес эхлүүлэх болон бизнест өөрчлөлт оруулахад зөвлөгөө өгөх</p> <p>Хяналт шалгалт - Бодлого, дүрэм журмын эрсдэлд суурилсан хяналт</p> <p>Мөрдөн шалгах, асуудлыг илрүүлэх - Хөгжил өөрчлөлт дээд удирдлагат хүрч буй эсэхийг тогтоох</p> <p>Үйл ажиллагааны комплайнс - Үйл явц болон горимууд</p> <p>Зохицуулалтын харилцаа - Зохицуулагч байгууллагууд үйл ажиллагаагаа явуулах, зохицуулалтын тайланг илгээхэд хамтарч ажиллах харилцааг зохицуулах</p>	<p>Бизнесийн зөвлөх харилцаанд оролцоходоо хараат бус бие даасан хяналтын чиг үүргийг баримтлах - Хараат бус бие даасан дүгнэлт гаргах, өдөр тутмын үйл ажиллагаа ба зөвлөгөө өгөх хоорондын зөрчлийг тэнцвэржүүлэх</p> <p>Бизнес загвар болон үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах - Автомат платформ, алгоритм, төрөл бүрийн харилаа холбооны сүлжээ ашиглахтай холбоотой өөрчлөлт хийх</p> <p>Хяналт шалгалт - Хамгаалалтын нэг, хоёрдугаар шугамын эрсдэлд үзүүлэх нөлөөллийг шинжлэх</p> <p>Автоматжуулалтын үе шат - Бизнесийн нарийн асуудлуудыг түргэн шуурхай үр дүнтэй шинжилж, хянах</p> <p>Дээд удирдлагын хариуцлагууд</p>	<ul style="list-style-type: none"> • Бизнесийг шинээр эхлүүлэх, өөрчлөлт оруулахад хараат бус бие даасан стратегийн зөвлөгөө өгөх • Бизнесүүдэд тулгарч сорилт бэрхшээл • Бизнесүүд нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтууддаа хүрч багаа эсэхийг хянах зөвлөх • Гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр хангаж зохицуулагч байгууллагатай хамтарч ажиллахад дэмжлэг үзүүлэх • Зохицуулагч байгууллагаас санал зөвлөгөө өгөх, байгууллагуудтай харилцахад дүрэм журамд өөрчлөлт оруулах

Эх сурвалж: (The Scope and Evolution of Compliance, 2018)

Зураг 0.4 Комплайнсын үүрэг

Комплайнсын үүрэг	Бизнесийн өөрчлөгдөж буй хэлбэрт тохиромжтой хэлбэрээр дэмжиж ажиллах
	Стратегийн төлөвөлт хийх чадвар бүхий үйл ажиллагаа эрхлэх
	Эрсдэлийг тодорхойлох таних ажил хийх
	Комплайнсын үүргийг давтамжтай эргэн хяналт хийх
	Мэргэжлийн ур чадварын хэрэгцээ шаардлагуудаа үнэлж комплайнсын үүргийг хэрэгжүүлэх ур чадвар, нөөц чадамж, туршлагатай байх
	Комплайнсын мэргэжилтэн нь туршлагатай бас хөрвөх чадвартай байхаар сонгох
	Өгөгдөл мэдээллийг боловсруулах технологийн үр ашгийг нэмэгдүүлэх

Эх сурвалж: (KPMG, 2020)


Комплайнс нь үүрэг хариуцлага биелүүлэхийн тулд хэд хэдэн сорилттой тулгардаг бөгөөд үүнд: байгууллагын байр суурь салбарын үүрэг, шинэ өөрчлөгдөж буй ур

чадварын хэрэгцээ, бизнесийн загваруудын өөрчлөгдөж буй шинж чанар, үйл явцын хурдтай өөрчлөлт, автоматжуулалт ахисан түвшний албан тушаалтанд тавигдах хариуцлагын шаардлагыг нэмэгдүүлсэн байдал. (Association for Financial Markets in Europe, 2018)

1.3 Комплайнсын удирдлага, оролцогч талууд

Комплайнсын чиг үүргийн хүрээнд харилцдаг дотоод болон гадаад оролцогч талууд, комплайнсын удирдлага ба оролцогч талуудын тодорхой хүлээлт, шаардлагын эсрэг хэрхэн нөлөөлж болохыг доорх хүснэгтээр тайлбарласан болно.

Зураг 0.5 Комплайнсын 2023 оны тэргүүлэх 10 удирдлага



Эх сурвалж: (Klöver, 2023)

Хүснэгт 0.2 Комплайнсын удирдлага ба оролцогч талууд

	ТУЗ	Бусад дотоод газар нэгжүүд /Хүний нөөц, ИТ, Эрсдэлийн удирдлагын газар/	Бизнес	Зохицуулагчид
Комплайнс	Бизнесийн загвар стратеги төлөвлөлтөөс бий болох эрсдэлийг үнэлэх	Комплайнсын эрсдэлийн удирдлага хэрэгжүүлэх үед сорилт тулгарвал бүх оролцогч талууд хамт шийдвэрлэх.	Одоогийн болон бизнесийн чиг хандлагыг зөв тодорхойлох	Бизнесийн нөхцөл харилцагчийн талаас комплайнсын эрсдэлийг тодорхойлох
	Компанийн комплайнсын шаардлагуудыг хангаж буй байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх	Эцсийн үр дүнг үнэлэн дүгнэхэд мэдээллээр хангах	Компани зохицуулалтын гэрээний дагуу үүрэг хариуцлагаа биелүүлэхэд сургалтаар хангах	Зохицуулалтын шаардлагуудын талаар ойлголттой болгох, сургалт хийх
	Компанийн комплайнс болон зан төлөв, соёлыг үнэлэх, санал хүсэлт гаргах	Бизнесийн тодорхой хэсгүүдэд эрсдэл үүсэхээс сэргийлэхэд хамтран ажиллах	Зохицуулалтын шаардлагуудыг хангахад өдөр тутмын асуулуудад оновчтой түргэн шуурхай зөвлөгөөгөөр хангах	Зах зээл болон үйлчлүүлэгчдээс бий болох үр ашгийн талаар тал бүрийн ойлголттой байх
Одоо болон цаашдын комплайнсын чиг	Шаардлагатай хэсгүүдэд нөөц ур чадваруудаар хангах	Шинэ бүтээгдэхүүн	Дотоод комплайнсын ойлголт	

хандлагыг тодорхойлж түүнд тохирсон санал зөвлөмжөөр хангах		үйлчилгээг туршиж, үнэлэх	мэдлэгийг хүртээмжтэй байлгах
---	--	---------------------------	-------------------------------

Эх сурвалж: (The Scope and Evolution of Compliance, 2018)

1.4 Комплайнсын чиг хандлага

Комплайнсын үйл ажиллагааны шинэ хэлбэрт шилжихийн тулд мэдээлэл боловсруулах төдий бус мэдээллийг оновчтой хэрэглэх хэрэгтэй юм. Комплайнсын эрсдэлийг тодорхойлох, хараат бус байх, зөвлөгөө боловсруулан ажиллахын тулд бүх мэдээллийн урсгалыг (гүйлгээний, зан үйлийн болон нийгмийн) ашиглан үйл ажиллагаандаа бодит хэрэглээ болгохыг эрэлхийлэх шаардлагатай байна.

Хараат бус байдал: Зохицуулагч байгууллагын шаардлагын дагуу комплайнс нь хараат бус байдлын 2-р шугамын үүрэгтэй ажилладаг. 2-р шугам гэдэг нь тохиолдол, хяналтыг хослуулан сорилт, үнэлгээ шалгалтын үүрэг хариуцлагыг бий болгох, бизнесийн хяналт, бизнесийн шинэ санаачилга, бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгөх, хэлэлцээр хийх замаар зохицуулалтын хүлээлтэд нийцүүлэх явдал юм. Комплайнс нь бизнесийн ашгийн төлөө шийдвэр гаргалтаас хараат бус бие даасан байх нь чухал нөлөөтэй хэдий ч бизнесийн стратеги, төлөвлөгөөг биелүүлэхэд оролцох нэгж юм.

Хяналт ба шалгалт: Комплайнс нь хяналтын үйл ажиллагааны загвар, үр дагавар зах зээлийн болон үйлчлүүлэгчийн тэнцвэртэй байдал, бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны стандартууд болон зан байдал зэргийг бий болгохын тулд хяналт шалгалтын гол үүрэг гүйцэтгэдэг. Хамгаалалтын нэгдүгээр шугамын туршигдсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ба комплайнсын хяналт шалгалтын үр дүн нь шударга, үнэн зөв байдаг.

Эрсдэлийн үнэлгээ: Эрсдэл, хяналтыг үнэлэхэд комплайнсын үүрэг оролцоо өөрчлөгдөж болдог. Судлаачид зарим жижиг байгууллагуудын зохицуулалтын эрсдэлийг үнэлэх, бизнесийн хамрах хүрээнд хяналтыг тодорхойлоход комплайнс чухал ба цаашид эрсдэлийг тодорхойлж, бизнес болон холбогдох хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй 1-р шугамын чиг үүрэгтэй холбоотой өөрчлөгдөх магадлалтай гэж таамаглаж байна.

Зураг 0.6 Комплайнсын зохицуулалтын өөрчлөлт



Эх сурвалж: (Ten key regulatory challenges of 2021, KPMG)

Комплайнс нь эрсдэлийн үнэлгээний үр дүнг баталгаажуулах ба хяналт шалгалтын тусламжтайгаар аль эрсдэл илрүүлэхэд төвөгтэй гэдгийг тодорхойлох, тухайн эрсдэлийн эсрэг тохирсон иж бүрэн, үр дүнтэй ямар хяналтын аргыг хэрэгжүүлэх эсэхийг шийдэхэд эрсдэлийн үнэлгээ хэрэгтэй болно. Комплайнс нь дараах үйл ажиллагааны хамрах хүрээнд чиг үүргээ нэмэгдүүлж болно. (Association for Financial Markets in Europe, 2018)

Бүлгийн дүгнэлт

- Судалгааны дүгнэлтээр зохицуулагч байгууллага өргөжин тэлж буй зах зээлийн өөрчлөлтүүдийг дагаж комплайнсын эрсдэлийг үнэлэх арга зүй болон үр дүнд тохирсон сургалт мэдээллийн хүртээмжтэй байдал дээр шаардлагатай өөрчлөлт хийх сорилтууд хүлээгдсээр байна. Комплайнсын үйл ажиллагааг технологи автоматжуулалт дээр суурилсан хяналт тавих, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх зэрэг хөгжлийн шинэ хэлбэрт хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй болж байна.
- Бизнесийн ялгаатай хэлбэр болон байгууллагын онцлогт тохирсон ТУЗ комплайнсын чиг хандлагыг тодорхойлж түүнд тохирсон санал зөвлөмжөөр хангах, байгууллагын дотоод газар нэгжүүд шаардлагатай хэсгүүдэд нөөц ур чадваруудаар хангах, бизнес шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг туршиж үнэлэх, зохицуулагч байгууллагууд салбарт хамаарах комплайнсын талаарх тодорхой зураглал бий болгох гэх мэт удирдлага оролцогч талуудын үүргүүд нэмэгдсээр байна.
- Комплайнсыг байгууллагын соёл, ажилтнуудын зан төлөв, хандлагад нөлөөлөх замаар тогтвортой хэвшүүлэх шаардлагатай ба цаашдаа шинээр бизнес эхлүүлэх болон өөрчлөлт оруулах үед нь хараат бус бие даасан стратегийн зөвлөгөө өгөх, бизнесүүдэд тулгарах сорилт бэрхшээл үүсэх үед болон бизнесүүд нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтууддаа хүрч багаа эсэхийг хянах зөвлөх, гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр хангаж зохицуулагч байгууллагатай хамтарч ажиллахад дэмжлэг үзүүлэх, зохицуулагч байгууллагаас санал зөвлөгөө өгөх болон байгууллагуудтай харилцахад дүрэм журамд өөрчлөлт оруулах бүхий л үе шатууд дээр сургалт мэдээллээр хангах үүргийг хангаж ажиллах хэрэгтэй болж байна.
- Байгууллагын бизнесийн үйл ажиллагааны онцлог ялгаатай байдлаас хамаарсан бие даасан дотоод харилцагчийг таньж мэдэх дүрэм журам, үйл ажиллагааны эрсдэлийг удирдах программ, платформуудыг ашиглах нь зардал бууруулах мөн дижитал шилжилт хийх давуу талуудыг бий болгож байна.
- Комплайнсын эрсдэлийг тасралтгүй хянах шинжилгээ хийх, үнэлэх нь байгууллагын хувьд нарийн төвөгтэй зардал их болох тул стандарт дагаж мөрдөх дүрэм журмыг байгууллагын бүх түвшний ажилтан удирдлага ойлгож хэрэгжүүлдэг байх нь олон талын давуу талуудыг бий болгоно.
- Судлаачдын дүгнэж байгаагаар бага зардлаар тасралтгүй хяналтыг үр дүнтэй хийхийн тулд дижитал шилжилт, сургалт мэдлэг ур чадвар, бүх түвшний ажилтнуудын ойлголт, дотоод бодлого дүрэм журам, дагаж мөрдөх өдөр тутмын соёл, ажлын байрны хэрэгжүүлэх үйл ажиллагаа хамгийн том нөлөөлөгч хүчин зүйлс болоод байна.

БҮЛЭГ 2: ОЛОН УЛСЫН ТҮВШИНД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН КОМПЛАЙНСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Санхүүгийн зах зээлийн комплаинсын эрхзүйн орчны талаар судлахын тулд санхүүгийн зах зээлийн эрхзүйн орчныг бүхлээр нь авч үзэх шаардлагатай болно. Олон улсын түвшин дэх санхүүгийн зах зээлийн хууль, эрхзүйн орчныг судлахын тулд жишиг болж болохуйц улс орнуудыг тодорхойлох зорилтыг судлаачид тавьсан. Олон улсын түвшинд санхүүгийн зах зээлийн гүнзгийрэлт, дэд бүтэц, хөгжлийг илэрхийлэх индикаторуудыг томоохон судалгааны байгууллагуудыг гаргаж байгаа боловч бидний судлахыг хүсэж байгаа санхүүгийн зах зээлийн хууль, эрхзүйн орчны үнэлгээг оруулж өгсөн индексийг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкнаас гарган тайланг хэвлүүлсэн (ЕСБХБ, 2021). Энэхүү тайланд улс орнуудын санхүүгийн зах зээлийн хөгжлийн индексийг 2014 он болон 2020 оны байдлаар индексэд авч үзэж буй 4 гол үзүүлэлтүүдээр тэргүүлэгч улсуудтай хэр ойр байгаа вэ гэсэн үндсэн үзүүлэлтээр тооцон гарган танилцуулсан. Индексийг тооцохдоо санхүүгийн зах зээлийн хөгжлийг илэрхийлэх гол үзүүлэлтүүдээр макро эдийн засгийн орчин, санхүүгийн зах зээлийн эрхзүйн орчин, санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, хөрөнгө оруулагчдын бүтцийг авсан байна (ЕСБХБ, 2021).

Хүснэгт 0.1 Санхүүгийн зах зээлийн хөгжлийн индекс

Улсууд	Индекс		Зах зээлийн гүнзгийрэлт		Индексийг бүрэлдэхүүн /2020/			
	2020	2014	2020	2014	Макро эдийн засгийн орчин	Эрхзүйн орчин	Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц	Хөрөнгө оруулагчдын бүтэц
Япон	96.30	96.80	81.20	71.90	90.00	98.70	100.0	96.60
Швед	94.70	93.80	79.80	70.10	93.90	99.40	100.0	85.40
Канад	93.80	93.00	91.80	79.10	91.40	98.50	100.0	85.20
АНУ	93.60	92.60	99.60	93.80	91.20	97.20	100.0	85.80
Их Британи	92.30	94.40	89.00	86.20	82.70	97.10	100.0	89.50
Франц	89.60	89.70	86.60	86.50	93.50	95.70	100.0	69.10
Герман	87.20	87.80	83.0	71.30	94.70	98.00	100.0	56.20
Монгол	36.30	22.20	8.10	7.50	58.30	36.70	33.0	17.40

Эх сурвалж: (Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк, 2021)

Уг тайланд Монгол Улсын индексийг мөн харуулсан. Индекс нэмэгдэх тусам санхүүгийн зах зээлийн гүнзгийрэлт буюу санхүүгийн зах зээлд хийгдэж байгаа гүйлгээний тоо, хэмжээ нэмэгдэж байгаа гэдгийг тайланд дурдсан байна. Өөрөөр хэлбэл, санхүүгийн зах зээлийн хөгжлийн индекс нэмэгдэх тусам зах зээлийн идэвх нэмэгддэг гэдэг нь энэ судалгаагаар харгасан (ЕСБХБ, 2021). Санхүүгийн зах зээлийн хөгжлийн индекс хамгийн өндөртэй улсууд болох Япон, Швед, АНУ, Их Британи, Герман гэх мэт улсуудын санхүүгийн зах зээлийн зохицуулалтын эрхзүйн орчны талаарх мэдээллийг зохицуулагч төв байгууллагуудын нээлттэй мэдээллүүдээс авч үзэхэд санхүүгийн байгууллагуудын комплаинсын зохицуулалт гэдэгт олон улсын түвшинд банк, зээлийн хоршоо, хөрөнгө оруулалтын сан, даатгалын компани болон бусад санхүүгийн байгууллагууд холбогдох хууль тогтоомж, журам заавар, салбарын стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулахын тулд авч хэрэгжүүлж буй үйл явц, арга хэмжээг хэлнэ. Санхүүгийн байгууллагууд нь комплаинсын үндсэн зорилго буюу тухайн улс орнуудын

зохицуулагч байгууллагуудын санхүүгийн системийн нэгдмэл байдлыг хамгаалах, хэрэглэгчдийг хамгаалах, системийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц, байнга хөгжиж буй зохицуулалтын тогтолцоонд захирагддаг.

Зураг 0.1 Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын баримт бичгүүд



Эх сурвалж: Судлаачдын нэгтгэлээр

Дээрх улсуудын санхүүгийн байгууллагуудын зохицуулалтын эрхзүйн баримт бичгүүдийг авч үзвэл нийтлэг зайлшгүй байх хууль, журам заавруудыг судлаач бид дээрх зурагт харууллаа. Эдгээр бичиг баримтуудад:

1. *Мөнгө угаахтай тэмцэх (AML) болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (CTF)*: Санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулах явцад хууль бус үйл ажиллагаанд өртөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд МУТ болон ТСТ арга хэмжээг хатуу хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд: үйлчлүүлэгчийн зохих шалгалтыг хийх, сэжигтэй үйл ажиллагаатай холбоотой гүйлгээг хянах, аливаа сэжигтэй гүйлгээг зохицуулах байгууллагад мэдээлэх зэрэг орно.
2. *Харилцагчийг таньж мэдэх (KYC)*: Санхүүгийн байгууллагууд үйлчлүүлэгчдийнхээ хэн болохыг баталгаажуулах, эрсдэлийг үнэлэх процессуудыг бий болгож, хадгалах мөн байнга шинэчилж байх шаардлагатай байдаг. Үйлчлүүлэгчээ танин мэдэх журам нь залилан, мөнгө угаах болон бусад хууль бус үйлдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд тусалдаг.
3. *Хөрөнгийн хүрэлцээ ба эрсдэлийн удирдлага*: Санхүүгийн байгууллагууд санхүүгийн тогтвортой байдлаа хангахын тулд өөрийн эзэмшиж буй хөрөнгийн хэмжээ, чанарыг тодорхойлсон зохицуулалтыг дагаж мөрдөх ёстой. Үүнд: стресс тест хийх, хөрвөх чадварыг хангалттай байлгах, тэдний үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, зээлийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг удирдах зэрэг багтана.
4. *Хэрэглэгчийн эрхийг хамгаалах*: Санхүүгийн байгууллагууд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн зохицуулалтыг дагаж мөрдөх ёстой. Үүнд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ил тод, шударга болгох, зээлийн хариуцлагатай үйл ажиллагааг хангах, харилцагчдын гомдол, маргааныг шийдвэрлэх зэрэг орно.
5. *Мэдээллийн хамгаалалт ба нууцлал*: Санхүүгийн байгууллагууд харилцагчийн бүхий л мэдээлэлтэй харьцдаг бөгөөд мэдээллийн хамгаалалт, нууцлалын зохицуулалтыг дагаж мөрддөг байхыг шаарддаг. Санхүүгийн байгууллагууд хувийн мэдээллийг хамгаалах, мэдээлэл боловсруулах, дамжуулахад

шаардлагатай зөвшөөрөл авах, мэдээлэл хамгаалах ерөнхий журам эсвэл бусад холбогдох өгөгдөл хамгаалах хууль зэрэг зохицуулалтыг дагаж мөрдөх хамгаалалтыг бий болгох ёстой.

6. *Үнэт цаас, хөрөнгө оруулалтын зохицуулалт*: Үнэт цаасны арилжаа, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, хөрөнгө оруулалтын санг удирдах үйл ажиллагаа эрхэлдэг санхүүгийн байгууллагууд зах зээлийн шударга байдал, мэдээллийг ил тод болгох шаардлага, хөрөнгө оруулагчдын хамгаалалт, тусгай зөвшөөрлийн шаардлагуудтай холбоотой зохицуулалтыг дагаж мөрдөх ёстой.
7. *Санхүүгийн тайлагналын болон нягтлан бодох бүртгэлийн стандартууд*: Санхүүгийн байгууллагууд нь санхүүгийн тайланг үнэн зөв, ил тод гаргахын тулд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд эсвэл олон улсын санхүүгийн тайлангийн стандартууд (СТОУС) зэрэг санхүүгийн тайлангийн стандартыг дагаж мөрдөх ёстой.
8. *Зохицуулалтын тайлан ба комплайнсын мөрдөх хяналт*: Санхүүгийн байгууллагууд шаардагдах санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг зохицуулах байгууллагад тайлагнах шаардлагатай болно. Санхүүгийн байгууллагууд зохицуулалтын шаардлагуудыг дагаж мөрдөж байгаа эсэхийг хянах, тайлагнах найдвартай систем, процессыг бий болгох ёстой.

Зохицуулалтын үүргээ биелүүлээгүй тохиолдолд санхүүгийн торгууль ногдуулах, нэр хүндээ алдах, тусгай зөвшөөрлөө цуцлуулах, хуулийн хариуцлага хүлээлгэх зэрэг ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй. Үүний үр дүнд санхүүгийн байгууллагууд зохицуулалтын шаардлагыг тасралтгүй дагаж мөрдөж, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахын тулд комплайнс хариуцсан газар, хэлтэст хөрөнгө оруулалт хийж, комплайнсын ажилтнуудыг ажиллуулдаг. Эдгээр газар, хэлтэс нь тухайн байгууллага үйл ажиллагаагаа зохицуулалтын бүхий л эрхзүйн баримт бичгүүдийн нийцтэй явуулж байгаа эсэхэд хяналт тавихын зэрэгцээ комплайнсын бодлого боловруулж, хэрэгжүүлэх, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, дотоод аудит хийх гэх мэт үндсэн чиглэлээр ажилладаг.

2.1 Санхүүгийн зах зээлийн комплайнсын эрх зүйн зохицуулалтын тэргүүн туршлага

Олон улсын жишиг болгож санхүүгийн зах зээлийн хөгжлийн индекс болон индексийн хууль эрхзүйн зохицуулалтаар хамгийн сайн гэж үнэлгээг авсан Япон улсыг тэргүүн туршлагаар сонгон авч эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг судлахаар сонголоо. Японы санхүүгийн зах зээл дэх байгууллагуудын үйл ажиллагааг заавал дагаж мөрдөх хууль, журам заавруудаар зохицуулдаг. Гол хуулиудаас дурдвал:

а) Санхүүгийн хэрэгсэл ба биржийн тухай хууль (Financial Instruments an Exchange Act): СХБТХ нь Япон дахь үнэт цаас болон деривативтай холбоотой үйл ажиллагааг зохицуулдаг. Уг хууль нь санхүүгийн байгууллагуудад тавигдах тусгай зөвшөөрлийн шаардлага, мэдээллийг ил болгох үүрэг, дотоод мэдээлэл, зах зээлийн манипуляци, хөрөнгө оруулагчдын хамгаалалт зэрэг үндсэн асуудлуудыг хамардаг. Анх 1948 онд батлагдаж, хамгийн сүүлд томоохон нэмэлт өөрчлөлт 2006 онд орсон.

б) Банкны тухай хууль (Banking Act): Банкны тухай хууль нь Японы банкуудын зохицуулалтын тогтолцоог бүрдүүлж өгдөг. Үүнд тусгай зөвшөөрлийн шаардлага, өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа, засаглалын стандарт, эрсдэлийн удирдлага,

харилцагчийн хамгаалалт, санхүүгийн байгууллагуудын шийдвэрлэлт зэрэг гол агуулгыг багтаана. 1927 онд батлагдаж, 2019 онд сүүлд томоохон нэмэлт өөрчлөлт оржээ.

в) Даатгалын бизнесийн хууль (Insurance Business Act): ДБХ нь Япон дахь даатгалын компаниуд болон даатгалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулдаг. Үүнд: даатгалын компаниудын тусгай зөвшөөрөл, хөрөнгийн хүрэлцээ, бүтээгдэхүүний төрөл, даатгуулагчийн хамгаалалт, санхүүгийн тайлангийн шаардлага зэрэгтэй холбоотой заалтууд багтсан байдаг. Уг хууль нь 1996 онд батлагджээ.

г) Төлбөрийн үйлчилгээний тухай хууль (Payment Services Act): Төлбөрийн үйлчилгээний тухай хууль нь Япон дахь төлбөр тооцооны үйлчилгээ болон цахим мөнгө гаргагчдыг зохицуулдаг. Уг хууль нь төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгчдийн тусгай зөвшөөрлийн шаардлага, мөнгө угаахтай тэмцэх арга хэмжээ, мэдээлэл хамгаалах заалт, маргааныг шийдвэрлэх журмыг тогтоодог. Энэхүү хууль нь 2009 онд батлагджээ.

д) Гэмт хэрэгтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэхээс сэргийлэх тухай хууль (Act on Prevention of Transfer of Criminal Proceeds): Уг хууль нь Япон дахь мөнгө угаахтай тэмцэх (AML) болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (CTF) шаардлага, зохицуулалтыг тогтоодог. Санхүүгийн байгууллагууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор тэдгээртэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх, харилцагчийн хяналт шалгалтыг явуулах, сэжигтэй гүйлгээг мэдээлэх, дотоод хяналтыг бий болгох үүрэгтэй. Энэхүү хууль нь 1991 онд батлагджээ.

е) Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (Act on the Protection of Personal Information): Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль нь Япон дахь хувийн мэдээлэлтэй ажиллах асуудлыг бүхэлд зохицуулдаг. Санхүүгийн байгууллагууд нь хувийн мэдээллийн хамгаалалт, мэдээлэл цуглуулах, ашиглах зөвшөөрөл, мэдээллийн аюулгүй байдал, хувь хүний эрхтэй холбоотой шаардлагыг дагаж мөрдөх ёстой. Энэхүү хууль нь 2003 онд батлагджээ.

ё) Санхүүгийн хэрэгслийн борлуулалтын хууль (Act on Sales of Financial Instruments): Уг хууль нь Япон дахь санхүүгийн хэрэгслийн борлуулалт, эзэмшигчийн шилжилтийн асуудлуудыг зохицуулдаг. Мөн борлуулалтын практик, хэлэлцээрийн шаардлага, ил тод болгох үүрэг, санхүүгийн байгууллагуудын бизнесийн үйл ажиллагаа зэрэг салбаруудыг хамардаг. Энэхүү хууль нь 1948 онд батлагджээ.

ж) Хөрөнгө оруулалтын траст ба хөрөнгө оруулалтын корпорацийн тухай хууль (Act on Investment Trusts and Investment Corporations): Уг хууль нь Япон дахь хөрөнгө оруулалтын траст болон хөрөнгө оруулалтын корпорациудын үйл ажиллагааг зохицуулдаг. Үүнд: хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын корпораци байгуулах, ажиллуулах, удирдах, зохицуулахтай холбоотой зохицуулалтууд багтсан. Энэхүү хууль нь 2006 онд батлагджээ.

з) Гадаад валютын болон гадаад худалдааны тухай хууль (Foreign Exchange and Foreign Trade Act): Уг хууль нь Япон дахь гадаад валютын арилжаа, гадаад валютын гүйлгээ, гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулдаг. Мөн гадаад валютын солилцоо, хөрөнгийн урсгал, гадаадын зарим хөрөнгө оруулалтыг хязгаарлах зэрэг салбаруудыг хамардаг. Энэхүү хууль нь 1949 онд батлагджээ.

Япон улсын санхүүгийн байгууллагуудын зохицуулалтын орчин, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг авч үзэхийн тулд санхүүгийн байгууллагуудыг хянах,

зохицуулах үүрэгтэй зохицуулалтын байгууллагуудыг талаар авч үзэх нь зайлшгүй. Япон дахь үйл ажиллагаа явуулах санхүүгийн зах зээлийн гол зохицуулагч байгууллагууд нь:

а) *Санхүүгийн үйлчилгээний байгууллага (Financial Service Agency)*: Санхүүгийн үйлчилгээний байгууллага нь Японы санхүүгийн байгууллагуудыг зохицуулах үндсэн байгууллага юм. Уг байгууллага нь Японы Засгийн Газрын бие даасан агентлаг бөгөөд Сангийн яамны харьяанд ажилладаг. Санхүүгийн үйлчилгээний байгууллага нь Японы санхүүгийн системийн тогтвортой байдал, бүрэн бүтэн байдал, найдвартай байдлыг хянах, хангах үүрэгтэй. Мөн банк, даатгалын компаниуд, үнэт цаасны компаниуд болон бусад санхүүгийн байгууллагуудад хяналт тавьдаг.

б) *Санхүүгийн үйлчилгээний байгууллагын харьяа орон нутгийн санхүүгийн товчоонууд*: Санхүүгийн үйлчилгээний байгууллага нь Япон даяар байрладаг хэд хэдэн харьяа орон нутгийн санхүүгийн товчоотой. Эдгээр товчоонууд нь тодорхой бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн банк, зээлийн хоршоо болон бусад санхүүгийн байгууллагуудад хяналт тавьж, зохицуулах үүрэгтэй. Санхүүгийн байгууллагууд холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд Санхүүгийн үйлчилгээний байгууллагатай хамтран ажилладаг юм.


в) *Японы Төв Банк (Bank Of Japan)*: Японы Төв Банк нь санхүүгийн байгууллагуудын ялангуяа банкуудын зохицуулалт, хяналтад чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, төлбөр тооцооны системд хяналт тавих үүрэгтэй. Японы Төв Банк нь санхүүгийн системийн ерөнхий тогтвортой байдлыг хангахын тулд Санхүүгийн үйлчилгээний байгууллагатай нягт хамтран ажилладаг байна.

г) *Үнэт цаас, биржийн хяналтын хороо (Securities and Exchange Surveillance Commission)*: ҮЦБХХ нь үнэт цаасны зах зээл болон үнэт цаастай холбоотой үйл ажиллагааг хянадаг Санхүүгийн үйлчилгээний байгууллагын хяналт дор байдаг зохицуулалтын агентлаг юм. Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоог шударга, ил тод байлгах үүднээс хяналт шалгалтын болон зохицуулалтын үйл ажиллагаа явуулдаг. ҮЦБХХ нь хөрөнгө оруулагчдыг эрх ашгийг хамгаалах, Японы хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг хадгалах зорилготой юм.

д) *Японы Санхүүгийн Үйлчилгээний Холбоо (Japan Financial Services Association)*: Японы санхүүгийн үйлчилгээний холбоо нь Японы санхүүгийн байгууллагуудыг төлөөлдөг салбарын холбоо юм. Уг холбоо нь зохицуулах байгууллага биш ч санхүүгийн салбартай холбоотой асуудлаар өөрийгөө зохицуулах, салбарын стандарт тогтоох, зохицуулах байгууллагуудтай хамтран ажиллах үүрэг гүйцэтгэдэг.

Эдгээр зохицуулалтын байгууллагууд нь Японы санхүүгийн салбарын зохицуулалтыг бий болгох, хэрэгжүүлэх, санхүүгийн байгууллагуудад хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр бие даан болон хамтран ажилладаг юм байна. Зохицуулалтын байгууллагууд Японы санхүүгийн системийн тогтвортой байдал, бүрэн бүтэн байдал, ил тод байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.


Зураг 0.2 Комплайнсын бүрэлдэхүүн хэсэг



Эх сурвалж: Судлаачдын нэгтгэлээр

Улс орны комплайнсын зохицуулалтын эрхзүйн орчныг авч үзвэл хууль, тавигдах шаардлага, стандартууд, журам зааврууд, байгууллагын дотоод бодлогууд хамарна. Хуулиудыг хууль тогтоох байгууллагууд, тавигдах шаардлага, журам, заавруудыг тухайн зах зээлийг зохицуулалтын байгууллагууд, харин салбар стандартуудыг зохицуулагч байгууллагууд эсвэл санхүүгийн байгууллагуудын холбоод, харин байгууллагын дотоод бодлого, журам зааврыг санхүүгийн байгууллага бүр боловсруулан баталж хэрэгжүүлж ажиллаж байна.

Зураг 0.3 Комплайнсын 3 түвшний зохицуулалтын орчин



Эх сурвалж: Судлаачдын нэгтгэлээр

Өмнөх хэсэгт тухайн улсын санхүүгийн салбарын зохицуулалтын хуулиудыг Япон улсын түвшинд дурдаж харуулсан бол харин салбар бүрийн зохицуулалтын эрхзүйн баримт бичгүүд олон тооны байгаа тул нэг бүрчлэн дурдахаас зайлсхийлээ. Эдгээр бичиг баримт, журам зааврууд нь тухайн салбарын (даатгал, үнэт цаасны компаниуд гэх мэт) тогтвортой байдлыг хангах, харилцагчдын мэдээллийн нууцлалыг хадгалах, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг тэмцэх зэрэг санхүүгийн салбарын хуулиудын зорилготой нийцэж гарсан байдаг.

2.2 Санхүүгийн байгууллага бүрийн түвшний комплайнсын зохицуулалт

Санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа санхүүгийн байгууллага бүр дээр дурдагдсан улсын ерөнхий зохицуулалтын хуулиуд болон салбар бүрийн зохицуулагч байгууллагын баталж гаргасан журам, зааврын дагуу ажиллах шаардлагатайгаас гадна байгууллагын комплайнсын бүтцийг бий болгож, тодорхой газар хэлтэс, ажилтнуудыг комплайнсын чиглэлээр ажиллуулж, комплайнсын соёлыг бүрдүүлэх, сургалт хөгжүүлэлтийг байнга явуулж, комплайнсын бодлого, журам заавруудтай, тэдгээрийг бүхий л байгууллагын ажилтнууд хэрэгжүүлж ажилласнаар комплайнсын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нэр хүндтэйгээр, тогтвортой үйл ажиллагаагаа явуулах боломж бүрдэнэ. Олон улсын түвшинд санхүүгийн байгууллага бүр байгууллагын дотоод комплайнсын бүтэц, зохицуулах эрхзүйн орчныг бүрдүүлэх, удирдахдаа ISO 37301:2021 стандартын дагуу бий болгосноор оновчтой байна гэдгийг санхүүгийн салбар хөгжил сайтай байгаа улсуудын зохицуулах байгууллагуудын тайлангуудад дурджээ. Иймд судлаачдын зүгээс байгууллагын түвшинд уг стандартад дурдагдсан комплайнсын

бүтэц, бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, удирдахад нь зүйтэй гэж дүгнэлээ. ISO 37301:2021 нь "Комплайнсын удирдлагын систем" нэртэй олон улсын стандарт юм. Уг стандарт нь байгууллагуудад комплайнсын удирдлагын үр дүнтэй тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах, тасралтгүй сайжруулахад чиглүүлж, удирдамжаар хангадаг. ISO 37301:2021 стандартыг Олон улсын стандартчиллын байгууллага (ISO) нь байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам зааврууд болон бусад шаардлагыг дагаж мөрдөхөд нь туслах зорилгоор боловсруулсан (ISO, 2021).

ISO 37301:2021 стандартын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд болон шаардлагуудын задаргааг дараах хэсэгт харуулав.


1. Хамрах хүрээ, хэрэглэх боломж: Стандарт нь санхүүгийн байгууллагын хэмжээ, салбар, байршлаас үл хамааран бүх төрлийн байгууллагад хамаарч болно. Мөн янз бүрийн хууль эрх зүйн болон зохицуулалтын нөхцөл байдалд дасан зохицох боломжтой.
2. Комплайнсын удирдлагын тогтолцоо: ISO 37301 нь байгууллага доторх комплайнсын удирдлагын тогтолцоог бий болгохыг чухалчилдаг. Энэхүү тогтолцоо нь комплайнсын үүргээ үр дүнтэй тодорхойлох, үнэлэх, хянах, удирдахад зориулагдсан байх ёстой.
3. Манлайлал ба амлалт: Байгууллагын удирдлага нь комплайнсын удирдлагад манлайлах, дагуулж удирдах чухал үүрэг гүйцэтгэдэг. Удирдлага нь комплайнсын соёлыг бий болгох, комплайнсыг тодорхойлох, комплайнсын удирдлагад шаардлагатай нөөцийг хуваарилах үүрэгтэй.
4. Комплайнсын тогтолцоо: Байгууллагууд комплайнсын бодлого, үүрэг, хариуцлага, комплайнсын зорилго, комплайнсын эрсдэлийг удирдах үйл явцыг багтаасан комплайнсын тогтолцоог бий болгох шаардлагатай.
5. Комплайнсын эрсдэлийн үнэлгээ: Байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой комплайнсын эрсдэлийг тодорхойлж, үнэлэхийн тулд комплайнсын эрсдэлийн цогц үнэлгээг хийх ёстой. Үүнд: хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлага, дотоод бодлого, ёс зүйн хэм хэмжээг үнэлэх зэрэг орно.
6. Комплайнсын хяналт ба арга хэмжээ: ISO 37301 стандарт нь тогтоосон комплайнсын эрсдэлийг шийдвэрлэхийн тулд зохих хяналт, арга хэмжээг хэрэгжүүлэхийг чухалчилдаг. Үүнд: хяналтыг тодорхойлох, комплайнсын журам тогтоох, үр дүнтэй байдалд хяналт тавих зэрэг орно.
7. Комплайнсын гүйцэтгэлийн үнэлгээ: Байгууллагууд комплайнсын удирдлагын тогтолцооныхоо гүйцэтгэлийг үе үе үнэлж байх шаардлагатай. Үүнд: комплайнсын үйл ажиллагаанд хяналт тавих, комплайнсын аудит хийх, хяналт, үйл явцын үр нөлөөг шалгах зэрэг орно.
8. Комплайнсын сургалт ба харилцаа холбоо: ISO 37301 стандарт нь ажилтнууд болон оролцогч талуудад комплайнсын сургалт явуулахын чухлыг онцолж өгдөг. Стандарт нь комплайнсын үүрэг, хүлээлтийг ойлгохын тулд үр дүнтэй харилцааны сувгуудын хэрэгцээг онцолж өгдөг.
9. Дотоод тайлагнал ба мөрдөн шалгалт: Стандарт нь байгууллагуудаас комплайнсын асуудлын талаар дотооддоо тайлагнах суваг, түүний дотор мэдээлэх механизмыг бий болгохыг шаарддаг. Мөн стандарт нь мэдээлсэн зөрчлийг шуурхай, үр дүнтэй шалгах шаардлагатайг онцолдог.

10. Сайжруулалт ба залруулах арга хэмжээ: Байгууллагууд комплайнсын удирдлагын тогтолцоогоо тасралтгүй сайжруулахыг хичээх ёстой. Үүнд: зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах, комплайнсын зөрчлөөс суралцах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг орно.

ISO 37301 стандарт нь байгууллагуудад шаардлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор стандартын дагуу заавар, зөвлөмж өгдөг. Стандарт нь комплайнсын менежментийн идэвхтэй хандлагыг төлөвшүүлэх, шударга ёсны соёлыг сурталчлах, байгууллагууд хууль тогтоомж, комплайнсын зохицуулалтын үүргээ биелүүлэхийг баталгаажуулах зорилготой юм. ISO 37301 нь сертификатжуулалтын стандарт биш, харин байгууллагууд өөрсдийн комплайнсын удирдлагын тогтолцоог бий болгох, сайжруулахад ашиглах удирдамжийн стандарт гэдгийг анхаарах нь чухал юм. Сертификат авахыг хүсч буй байгууллагууд ISO 19600 стандартын дагуу холбогдох байгууллагад хандаж болно, үүнд нийцлийн удирдлагын тогтолцооны гэрчилгээ олгох зааварчилгааг өгдөг (ISO, 2021).

2.3 Монгол Улсын санхүүгийн салбарын комплайнсын эрх зүйн зохицуулалтын онөөгийн байдал

Санхүүгийн системийн зохицуулалтын хуулиуд: Жишиг авсан Япон болон бусад улсуудын банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын салбарын зохицуулалтын хууль, журам, заавруудыг Монгол Улсын санхүүгийн салбарын зохицуулалтын баримт бичгүүдтэй харьцуулан авч үзвэл зайлшгүй байх шаардлагатай эрхзүйн баримт бичгүүд ерөнхийдөө бүгд баглагдан хэрэгжээд үйлчлэн явж байгаа нь харагдаж байна. Доорх хүснэгтэд манай улсын одоо мөрдөгдөж үйлчилж байгаа банкнаас бусад санхүүгийн байгууллагуудыг зохицуулж буй хуулиудыг харууллаа.



Олон улсын түвшинд зайлшгүй дагаж мөрдөгдөж байгаа чухал зарим хуулиудыг 2021 онд батлан гаргажээ. Зах зээлийн зохицуулалтын гол хуулиудыг тэргүүн туршлага болгон авсан улсын хуулиудтай харьцуулан дараах хэсэгт үзүүлэв. Харьуулалтын үнэлгээг А, В, С, D, F буюу 5 үнэлгээний системээр үнэллээ.

Үнэлгээний үндэслэл: Япон дахь хуульд биржийн үйл ажиллагааг зохицуулалтыг сайтар оруулж өгсөн нь ялгаатай тал болсон ба үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа зохицуулалттай байгууллагуудын бүртгэл, зохицуулалтыг дэлгэрэнгүй нарийвчлан оруулж өгсөн байна. Манай улсын хувьд байгаа хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн зохицуулалтыг мөн оруулж өгчээ. Зах зээлийг тогтворжуулах үйл ажиллагааны талаар бүлэгтэй байгаа нь Монголын хуулиас ялгаатай. Хил дамнансан үйл

ажиллагааны зохицуулалтыг нарийвчлан оруулж өгсөн, шилжилтийн үе буюу шинээр үйл ажиллагаа эхлүүлж байгаа компаниудын хувьд зохицуулалтыг оруулж өгсөн нь ялгаатай байна.

Хүснэгт 0.2 Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хуулийн харьцуулалт

Японы хуулийн нэр	Хуулийн бүлгүүд	Бүлгийн товч агуулга	Монгол хуулийн нэр	Хуулийн бүлгүүд	Үнэлгээ
Санхүүгийн хэрэгсэл биржийн тухай хууль ба Санхүүгийн хэрэгсэл биржийн тухай хууль	Ерөнхий зүйл	Хуулийн танилцуулга, тодорхойлолт, зорилгыг дурдсан	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	Ерөнхий зүйл	Судалгааны багаас өгч буй үнэлгээ В-
	Үнэт цаасны компанийн бүртгэл	Үнэт цаасны компаниудын бүртгэлд тавигдах шаардлага, зохицуулалтын хүрээ, үүнд тусгай зөвшөөрөл олгох, тайлагнах үүргийг тусгасан.		Үнэт цаас гаргах, арилжих	
	Хөрөнгө оруулалтын зөвлөх, хөрөнгө оруулалтын менежерийн бүртгэл, зохицуулалт	Хөрөнгө оруулалтын зөвлөх, хөрөнгө оруулалтын менежерүүдэд тавигдах бүртгэл, зохицуулалтын шаардлагыг тодорхойлсон.		Компанийн хувьцааг бүхэлд нь буюу түүний хяналтын багцыг худалдан авах	
	Хөрөнгө оруулалтын итгэмжлэгдсэн компанийн бүртгэл, зохицуулалт	Хөрөнгө оруулалтын итгэмжлэгдсэн компаниудын (хамтын сангийн компаниуд) бүртгэл, зохицуулалтын шаардлагыг авч үздэг.		Зохицуулалттай үйл ажиллагаа	
	Санхүүгийн хэрэгслийн компаниудын зохицуулалт	Үнэт цаастай холбоотой төрөл бүрийн үйл ажиллагаа эрхэлдэг санхүүгийн хэрэглүүрийн компаниудад тавигдах зохицуулалтын шаардлагуудыг нарийвчлан тусгасан.		Үнэт цаасны зах зээлийн зохицуулалт	
	Биржийн зохицуулалт	Японд үйл ажиллагаа явуулж буй үнэт цаасны бирж, санхүүгийн фьючерс биржийн дүрэм, журмыг тогтоодог.		Үнэт цаасны зах зээлд хориглох үйл ажиллагаа	
	Байгууллагын мэдээллийг задруулах	Санхүүгийн тайлан гаргах, бусад мэдээллийг цаг тухайд нь ил болгох зэрэг хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад тавигдах шаардлагуудыг авч үздэг.		Судалгааны багаас өгч буй үнэлгээ В-	
	Бүртгэлтэй компаниудыг худалдан авах тендер	Худалдан авах тендерийг зохицуулж, шударга, ил тод худалдан авах үйл явцын дүрмийг хангадаг.			
	Дотоод мэдээлэл ба зах зээлийн манипуляц	Үнэт цаасны зах зээл дээр дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийх, зах зээлд манипуляц болон бусад зарилан мэхлэх үйл ажиллагааг хориглоно.			
	Олон нийтэд санал болгох ба хоёрдогч санал	Үнэт цаасыг олон нийтэд санал болгох, хоёрдогч санал болгох журам, зохицуулалтыг тусгасан болно.			
	Хөрөнгө оруулалтын зөвлөхүүд ба хөрөнгө оруулалтын менежерүүд	Хөрөнгө оруулалтын зөвлөхүүд болон хөрөнгө оруулалтын менежерүүдэд тавигдах шаардлага, мөн тэдний үйлчлүүлэгчдийн өмнө хүлээн үүрэг, хүлээн үүргийг тодорхойлсон.			
	Хөрөнгө оруулалтын трастууд	Хөрөнгө оруулалтын трастуудыг (хамтын сангууд), тэдгээрийн үүсгэн байгуулах, ажиллуулах, удирдах зэргийг зохицуулдаг.			
	Зах зээлийг тогтворжуулах	Үнэт цаасны зах зээлийг тогтворжуулах, зах зээлийн хямралыг арилгах арга хэмжээнүүдтэй холбоотой заалтуудыг агуулсан.			
	Захиргааны үйл ажиллагаа ба эрүүгийн шийтгэл	Хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх захиргааны арга хэмжээ, эрүүгийн хариуцлагыг тодорхойлсон.			
	Шилжилтийн үеийн заалтууд	Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд түүнийг хэрэгжүүлэхээс өмнө шилжилтийн зохицуулалт, заалтуудыг тусгасан.			

	Нэмэлт заалтууд	Хуулийн хэрэгжилт, хэрэгжилттэй холбоотой нэмэлт заалтуудыг агуулсан.			
--	-----------------	---	--	--	--

Ж сурвалж: Судлаачдын нэгтгэлээр

Үнэлгээний үндэслэл: Японы Даатгалын бизнесийн хуульд зохицуулж буй үйл ажиллагааг Монголын Даатгалын тухай хуульд зохицуулж буй заалтуудтай харьцуулан авч үзэхэд ялгаатай байдал ерөнхийдөө бага байсан. Харин даатгалын үйл ажиллагааны олон улсын хамтын ажиллагааг тусгаж өгсөн, мөн хариуцлага, санкцийн заалтыг нарийвчлан оруулсан нь бага зэрэг ялгарч байгаа юм.

Хүснэгт 0.3 Даатгалын үйл ажиллагааны зохицуулалтын хуулийн харьцуулалт

Японы хуулийн нэр	Хуулийн бүлгүүд	Бүлгийн товч агуулга	Монгол хуулийн нэр	Хуулийн бүлгүүд	Үнэлгээ
Даатгалын бизнесийн хууль	Ерөнхий зүйл	Хуулийн танилцуулга, тодорхойлолт, зорилгыг тусгагдсан.	Даатгалын тухай	Ерөнхий зүйл	Судалгааны багаас өгч буй үнэлгээ А-
	Даатгалын бизнес эрхлэх тусгай зөвшөөрөл, бүртгэл	Япон улсад даатгалын бизнес эрхлэх зөвшөөрөл авах, бүртгүүлэхэд тавигдах шаардлага, зохицуулалтыг тодорхойлсон.		Даатгалын ангилал, төрөл, хэлбэр	
	Удирдлага ба захиргаа	Даатгалын компаниудад тавигдах засаглал, зохион байгуулалт, захиргааны шаардлагууд, компанийн засаглал, эрсдэлийн удирдлагатай холбоотой дүрэм журмыг нарийвчлан тусгасан.		Даатгалын үйл ажиллагааг төрөө зохицуулах	
	Хөрөнгө, өр төлбөр	Хөрөнгө, өр төлбөрийн үнэлгээ, удирдлагын дүрэм, стандартыг тодорхойлсон.		Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох	
	Даатгалын үйл ажиллагаа	Андеррайтинг, нэхэмжлэлийн боловсруулалт, бүтээгдэхүүн боловсруулах зэрэг даатгалын үйл ажиллагааны асуудлыг зохицуулдаг.		Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тавих хяналт	
	Давхар даатгал	Даатгалын компаниудын давхар даатгалыг ашиглахтай холбоотой шаардлага, зохицуулалтыг хамарна.		Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, төлбөрийн чадвар	
	Мэдээллийг тодруулах ба тайлагнах	Санхүүгийн тайлан, даатгуулагчдад өгсөн мэдээлэл зэрэг тодруулга, тайлагналын шаардлагуудыг тусгасан.		Нягтлан бодох бүртгэл, аудит	
	Хяналт ба шалгалт	Даатгалын компаниудад хуулийн хэрэгжилтийг хангахад хяналт тавих, хянах зохицуулалтын байгууллагуудын эрх, үүргийг тодорхойлсон.		Актуарч, актуарын хяналт шалгалт, тайлан	
	Санкциуд ба захиргааны арга хэмжээ	Хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, торгууль, захиргааны арга хэмжээг зааж өгсөн.		Давхар даатгал	
	Олон улсын хамтын ажиллагаа	Хил дамнанас даатгалын үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор гадаадын зохицуулах байгууллагуудтай олон улсын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох боломжийг олгодог.		Даатгагчийн үүрэг, даатгагчид тавих хязгаарлал	
	Төрөл бүрийн заалтууд	Хуулийн хэрэгжилт, хэрэгжилттэй холбоотой янз бүрийн заалтуудыг агуулсан.		Зах зээлийн ёс зүй Нэрэнд хяналт тавих Хяналт шалгалт, мэдээлэл цуглуулах, тайлагнах Албадлага Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх, нэгтгэх Даатгагчийг татан буулгах Бусад зүйл	

Ж сурвалж: Судлаачдын нэгтгэлээр

Үнэлгээний үндэслэл: Японы Даатгалын бизнесийн хуульд зохицуулж буй үйл ажиллагааг Монголын Даатгалын тухай хуульд зохицуулж буй заалтуудтай харьцуулан авч үзэхэд ялгаатай байдал ерөнхийдөө бага байсан. Харин даатгалын үйл ажиллагааны

олон улсын хамтын ажиллагааг тусгаж өгсөн, мөн хариуцлага, санхүүгийн заалтыг нарийвчлан оруулсан нь бага зэрэг ялгарч байгаа юм.

Хүснэгт 0.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн харьцуулалт

Японы хуулийн нэр	Хуулийн бүлгүүд	Бүлгийн товч агуулга	Монгол хуулийн нэр	Хуулийн бүлгүүд	Үнэлгээ
Гэмт хэрэгтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэхээс сэргийлэх тухай хууль	Ерөнхий зүйл	Хуулийн нэр, тодорхойлолт, үндсэн зарчмуудыг тусгасан.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх	УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	Судалгааны багасаагч буй үнэлгээ А-
	Санхүүгийн байгууллагуудын үүрэг	Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх, сэжигтэй гүйлгээг мэдээлэх талаар банк, үнэт цаасны нүүс, даатгалын компаниуд зэрэг санхүүгийн байгууллагуудын хүлээх үүргийг тодорхойлсон.		Мэдээлэх үүрэгтэй этгээд	
	Зориулалтын санхүүгийн бус аж ахуйн нэгж, мэргэжлүүдийн үүрэг	Үл хөдлөх хөрөнгийн зуучлагч, хуульч, нягтлан бодогч зэрэг аж ахуйн нэгж, мэргэжлүүдийн мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх, сэжигтэй гүйлгээг мэдээлэх талаар хүлээх үүргийг тодорхойлсон.		Хариуцагчийг таньж мэдэх	
	Харилцагчийг таньж мэдэх	Үйлчлүүлэгчийг таних, баталгаажуулах журам, эрсдэлийн үнэлгээ, байнгын хяналт зэрэг хэрэглэгчийн зохих шалгалтанд тавигдах шаардлагуудыг нарийвчлан тусгасан.		Тусгай хяналт	
	Тайлагналын шаардлага	Сэжигтэй гүйлгээний талаар холбогдох байгууллагад мэдээлэх үүрэг даалгавар өгч, тайлагнах үйл явцын талаар зааварчилгаа өгнө.		Гүйлгээний талаар мэдээлэх	
	Бүртгэл хөтлөхөд тавигдах шаардлага	Санхүүгийн байгууллага болон бусад томилогдсон байгууллагуудын хөтлөх баримт бичгийн төрлийг эдгээр бүртгэлийг хадгалах хугацааны хамт зааж өгнө.		Хариуцагчийн талаарх баримт, материалыг хадгалах	
	Торгууль хэрэгжилт ба	Хяналт шалгалт, мөрдөн байцаалтын ажиллагаа зэрэг хуулийг дагаж мөрдөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага, түүнийг хэрэгжүүлэх механизмыг тодорхойлсон.		Сэжигтэй гүйлгээний тухай мэдээлэл	
	Олон улсын хамтын ажиллагаа	Мөнгө угаах, гэмт хэргийн шинжтэй орлоготой холбоотой олон улсын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох асуудлыг гадаадын туншүүдтэй шийдвэрлэх.		Дансанд хяналт тавих Хөрөнгө битүүмжлэх, түдгэлзүүлэх Хариуцагчаас чөлөөлөх Мэдээллийн нууцлалыг хадгалах Мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналт Монгол Улсын хилээр бэлэн мөнгө оруулах, гаргах Төрийн байгууллагын бүрэн эрх Санхүүгийн мэдээллийн алба Эрх бүхий хууль сахиулах байгууллагын чиг үүрэг Санхүүгийн мэдээллийн албаны чиг үүрэг Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналт Мэдээллийн сан Гадаад улсын ижил төстэй байгууллагатай харилцах	

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэлээр

Үнэлгээний үндэслэл: Японы Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн Монголын хуулиас ялгарах заалтууд мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлэх зохицуулалт, ялангуяа гадаад этгээдүүдэд шилжүүлэх зохицуулалт, аутсорсинг ашиглах, хохирлын нөхөн төлбөр, хариуцлагын нарийвчилсан заалтууд гэх мэтийг тусгаж, зохицуулдаг байна. Манай улсын хуулийн хувьд ерөнхий зохицуулалтыг хийж өгчээ.

Хүснэгт 0.5 Хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалтын хуулийн харьцуулалт

Японы хуулийн нэр	Хуулийн бүлгүүд	Бүлгийн товч агуулга	Монгол хуулийн нэр	Хуулийн бүлгүүд	Үнэлгээ
Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль	Ерөнхий зүйл	Хуулийн нэр, тодорхойлолт, үндсэн зарчмуудыг тусгасан.	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай	Ерөнхий зүйл	Судалгааны багасаагч буй үнэлгээ С
	Хувийн мэдээлэлтэй харьцах зохицуулалт	Бизнес, төрийн байгууллага зэрэг мэдээлэл боловсруулагчдын хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, задруулах, удирдахад тавигдах дүрэм, шаардлагуудыг нарийвчлан тусгасан болно.		Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах	
	Мэдээллийн хариуцагчийн эрх	Хувь хүний хувийн мэдээлэлтэй холбоотой эрх, тухайлбал гэдний мэдээлэлд хандах, засварлах, устгах эрхийг тодорхойлсон.		Мэдээллийн эзний эрх, үүрэг	
	Аюулгүй байдлын арга хэмжээ	Мэдээллийн боловсруулагчаас хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй нэвтрэх, алдах, алдагдахаас хамгаалахын тулд зохих аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаарддаг.		Мэдээлэл хариуцагч болон мэдээлэл боловсруулагч	
	Хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлэх	Хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд, тэр дундаа гадаадд байгаа аж ахуйн нэгжид шилжүүлэхийг зохицуулдаг бөгөөд өгөгдөл боловсруулагчаас зөвшөөрөл авах эсвэл ийм шилжүүлгийн тодорхой нөхцөлийг хангахыг шаарддаг.		Мэдээлэл хамгаалах үйл ажиллагаа	
	Тодорхой хувийн мэдээлэлтэй харьцах зохицуулалт	Нийгмийн даатгалын дугаар гэх мэт тодорхой төрлийн хувийн мэдээлэлтэй харьцах нэмэлт шаардлага, хамгаалалтыг тогтодог.		Мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага	
	Аутсорсинг хувийн мэдээлэлтэй ажиллах	Гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгчдийг татан оролцуулахдаа хувийн мэдээлэл боловсруулах аутсорсинг болон өгөгдөл боловсруулагчдын хариуцлагыг авч үздэг.		Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем	
	Ил тод болгох, нийтийн зорилгоор ашиглах	Төрийн байгууллагууд гэх мэт олон нийтийн зорилгоор хувийн мэдээллийг задруулах, ашиглах асуудлыг зохицуулдаг		Бусад зүйл	
	Дагаж мөрдөхийг баталгаажуулах арга хэмжээ	Хувийн мэдээллийг хамгаалах менежерийг томилох, дотоод бодлого, журмыг боловсруулах зэрэг хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг зааж өгсөн.			
	Захиргааны арга хэмжээ ба хариуцлага	Хяналт шалгалт, засч залруулах тушаал зэрэг хуулийг зөрчсөн тохиолдолд захиргааны арга хэмжээ, шийтгэл, хэрэгжүүлэх механизмыг тодорхойлсон.			
Хохирлын нөхөн төлбөр	Хувийн мэдээлэлдээ буруу хандсаны улмаас хохирсон хүмүүст нөхөн олговор олгох асуудлыг тусгасан.				
Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хуулийн шинэчлэгдэж буй технологи, практикт байгаа шинэчлэгдэхийн тулд хуулийг үе үе хянаж үзэх, нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой заалтуудыг агуулсан.				

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэлээр

Бусад зохицуулалтын хуулиудын харьцуулалт:
Харилцагчийг таньж мэдэх (KYC): Үйлчлүүлэгчээ танин мэдэх үйл ажиллагааны зохицуулалтыг олон улсуудад Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд тусгаж өгдөг. Харьцуулалт хийж буй Япон болон Монголын хувьд үйлчлүүлэгчээ танин мэдэх үйл ажиллагааг мөн тус хуулиар зохицуулж байгаа тул үнэлгээг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн харьцуулалтаар авах нь зүйтэй гэж үзэж байна.

Нягтлан бодох бүртгэлийн стандартууд: Харьцуулалт хийж буй улсуудын нягтлан бодох бүртгэлийн хуулиудын зохицуулалт, хамрах хүрээ ерөнхийдөө ижил байгаа тул Монгол улсын тус хуулийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулан хийсэн хууль гэж дүгнэж болно. Үнэлгээ А.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, хөрөнгийн хүрэлцээ ба эрсдэлийн удирдлага: Харьцуулалт хийж буй улсуудын хөрөнгийн хүрэлцээ, эрсдэлийн удирдлагын зохицуулалтыг үнэт цаасны зах зээлийн болон даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны зохицуулалтын хуулиудад тус бүр тусгаж өгсөн тул тэдгээр хуулиудын харьцуулалтын үнэлгээг ашиглах боломжтой.

Харин хэрэглэгчийн эрхийг хамгаалах заалтууд Японы зохицуулалттай салбарыг зохицуулж буй хуулиудад тусгаж өгсөн байдаг бол Монгол улсын зохицуулах хуулиудад ийм зохицуулалт байхгүй байна. Үнэлгээ F.

Зах зээлийн зохицуулалтын гол хуулиудын харьцуулсан үнэлгээнүүдээс авч үзвэл манай улсын хувьд хуулиудыг боловсруулан, хэрэгжиж явж байгаа нь харагдаж байгаа юм. Харин уг хуулиудын хэрэгжилтийн үнэлгээг хийх нь чухал байна. Мөн судалгааны гадаад харилцаа болон ауторсинг ашиглан үйл ажиллагаагаа сайжруулах, технологийн зохицуулалт гэх мэт заалтуудыг бусад улсын хуулиудыг судлан шинэчлэн өөрчлөх нь зүйтэй гэж дүгнэлээ.

Банкнаас бусад санхүүгийн зохицуулалттай салбарын зохицуулалт орчин: Санхүүгийн Зохицуулах хорооноос боловсруулан, батлан, хүчинтэй үйлчилж байгаа зохицуулалттай салбаруудыг зохицуулж буй журам, заавар, аргачлалууд нь олон тоотой байгаа тул нэг бүрчлэн дурдахаас илүү судлаачид бидний цуглуулсан мэдээллээс харахад зохицуулалттай бүх салбарын зохицуулалтын журмуудад комплайнсын удирдлагатай холбоотой дараах журмууд байгаа нь сайшаалтай байна. Үүнд: Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам, Компанийн засаглалын кодекс, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам, Салбаруудын ёс зүйн журам, Эрсдэлийн удирдлагын журам гэх мэт. Мөн байгууллагад дээр дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, удирдахад ашиглах зааврууд, аргачлалуудыг СЗХ-ны нээлттэй цахим хуудсанд оруулж өгчээ. Эдгээр журмууд нь санхүүгийн зах зээлийн хөгжил төдийгүй зохицуулалтын эрхзүйн орчны хөгжил өндөр улсуудын зохицуулалтын баримт бичгүүдтэй нийцэж байгаа юм.

Санхүүгийн байгууллага бүрийн зохицуулалтын орчин: Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталсан. Компанийн засаглалын кодекс тээс заасан заалтуудыг мөрдөхийг нээлттэй хувьцаат компани, даатгагч, банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааг эрхэлдэг компаниудад үүрэг болгож, бусад зохицуулалттай компаниудад зөвлөхөөр тусгажээ.

Тус КЗК-ийн 5.4-т зааснаар:

- Зохицуулалтын компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.
- Тайлбар №1 Төлөөлөн удирдах зөвлөл нь комплайнсын хяналтын заавар, жил бүрийн төсвийг батлан хүний нөөцийг томилж, шууд харьцана.
- Тайлбар №2 Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь комплайнсын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдэд шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг үзүүлж, бие даасан хараат бус байдлыг хангана гэж зааж өгсөн.

Ингэснээр Санхүүгийн Зохицуулах Хорооны зохицуулалтад байгаа байгууллагуудын хувьд уг заалтыг зайлшгүй хэрэгжүүлж ажиллах нөхцөл бүрдсэн. Мөн кодексийн хавсралт 10-т байгууллагуудын Комплайнсын хяналтын зааврын үлгэрчилсэн загварыг харуулсан. Комплайнсын хяналтын зааврын зорилго нь:

- Эрсдэлийн удирдлагыг бий болгох замаар компанийн засаглалыг сайжруулах;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх;
- Байгууллагын комплайнсын соёлыг бүрдүүлэх, төлөвшүүлэх, сургалт зохион байгуулах;
- Зөрчлийн талаар мэдээлэх "шүгэл үлээх" ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино гэж заасан.

Мөн уг зааварт дурдсанаар комплайнсын үйл ажиллагаа хараат бус, бие даасан байх, ил тод, нээлттэй байх, комплайнсын тогтолцоог бүрдүүлэхэд байгууллагын Төлөөлөн удирдах удирдлагын, гүйцэтгэх удирдлагын, компанийн ажилтны чиг үүргүүд, байгууллага комплайнсын заавал нэгж/ажилтантай байх, комплайнсын нэгж/ажилтны чиг үүрэг, комплайнсын дүрэм журам, зохицуулагч байгууллагатай харилцах, шүгэл үлээх ажиллагаа, тайлагнал гэсэн заалтуудаар зохицуулжээ. Монгол Улсын хувьд санхүүгийн салбарын комплайнсын зохицуулалтын эрхзүйн орчны судалгаанаас авч үзвэл макро түвшин дэх салбарын зайлшгүй байх хуулиуд батлагдан хүчинтэй үйлчилж байгааг, зохицуулалттай санхүүгийн салбар бүрийн журам, зааврууд батлагдан хүчинтэй үйлчилж байгааг харж байна. Харин байгууллагын түвшинд комплайнсын нэгж заавал байх ёстойг, комплайнсын бодлого, төсөвтэй зайлшгүй байх шаардлагатайг 2022 оноос дагаж мөрдөж байгаа ба СЗХ-ноос комплайнстай холбоотой суурь ойлголтууд, комплайнсын байгууллага дээрх удирдлагын талаарх сургалтуудыг идэвхтэй явуулж байна. Хэдий зохицуулалтын эрхзүйн баримт бичгүүд хүчинтэй үйлчилж байгаа боловч комплайнсын хэрэгжилт хэр байгаа вэ гэсэн асуудал гарч ирэх нь зайлшгүй билээ. Иймд одоо эдгээр зохицуулалтын талаарх зайлшгүй мэдэх шаардлагатай ойлголтууд, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа эсхийг судалж, үнэлэх нь чухал юм.

Бүлгийн дүгнэлт

- Санхүүгийн зах зээлийн хөгжлийн индекс хамгийн өндөртэй улсууд болох Япон, Швед, АНУ, Их Британи, Герман гэх мэт улсуудын санхүүгийн зах зээлийн зохицуулалтын эрхзүйн орчны талаарх мэдээллийг зохицуулагч төв байгууллагуудын нээлттэй мэдээллүүдээс авч үзэхэд санхүүгийн

байгууллагуудын комплайнсын зохицуулалт гэдэгт олон улсын түвшинд банк, зээлийн хоршоо, хөрөнгө оруулалтын сан, даатгалын компани болон бусад санхүүгийн байгууллагууд холбогдох хууль тогтоомж, журам заавар, салбарын стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулахын тулд авч хэрэгжүүлж буй үйл явц, арга хэмжээг хэлнэ.

- Санхүүгийн байгууллагууд нь комплайнсын үндсэн зорилго буюу тухайн улс орнуудын зохицуулагч байгууллагуудын санхүүгийн системийн нэгдмэл байдлыг хамгаалах, хэрэглэгчдийг хамгаалах, системийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц, байнга хөгжиж буй зохицуулалтын тогтолцоонд захирагддаг.
- Тухайн улсуудаас авч үзэхэд макро түвшинд зайлшгүй байх зохицуулагч хууль, эрхзүйн орчныг хэрэглэгчийн эрхийг хамгаалах, мөнгө угаах, терроризмыг дэмжихтэй тэмцэх, үйлчлүүлэгчээ таньж мэдэх, мэдээллийн хамгаалалт ба нууцлал, хөрөнгийн хүрэлцээ, эрсдэлийн удирдлага, үнэт цаас, хөрөнгө оруулалтын удирдлага, санхүүгийн тайлагналын стандартыг зохицуулсан хуулиудаар бүрдүүлсэн байна. Тухайн улс орны комплайнсын зохицуулалтын эрхзүйн орчныг авч үзвэл хууль, тавигдах шаардлага, стандартууд, журам зааврууд, байгууллагын дотоод бодлогууд хамарна.
- Хуулиудыг хууль тогтоох байгууллагууд, тавигдах шаардлага, журам, заавруудыг тухайн зах зээлийг зохицуулалтын байгууллагууд, харин салбар стандартуудыг зохицуулагч байгууллагууд эсвэл санхүүгийн байгууллагуудын холбоод, харин байгууллагын дотоод бодлого, журам зааврыг санхүүгийн байгууллага бүр боловсруулан баталж хэрэгжүүлж ажиллаж байна.
- Байгууллагын түвшинд байгууллагын комплайнсын бүтцийг бий болгож, тодорхой газар хэлтэс, ажилтнуудыг комплайнсын чиглэлээр ажиллуулж, комплайнсын соёлыг бүрдүүлэх, сургалт хөгжүүлэлтийг байнга явуулж, комплайнсын бодлого, журам заавруудтай, тэдгээрийг бүхий л байгууллагын ажилтнууд хэрэгжүүлж ажилласнаар комплайнсын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нэр хүндтэйгээр, тогтвортой үйл ажиллагаагаа явуулах боломж бүрдэнэ.
- Олон улсын түвшинд санхүүгийн байгууллага бүр байгууллагын дотоод комплайнсын бүтэц, зохицуулах эрхзүйн орчныг бүрдүүлэх, удирдахдаа ISO 37301:2021 стандартын дагуу бий болгосноор оновчтой байна гэдгийг санхүүгийн салбар хөгжил сайтай байгаа улсуудын зохицуулах байгууллагуудын тайлангуудад дурджээ.
- Иймд судлаачдын зүгээс байгууллагын түвшинд уг стандартад дурдагдсан комплайнсын бүтэц, бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, удирдахад нь зүйтэй гэж дүгнэлээ.
- Монгол Улсын хувьд санхүүгийн салбарын комплайнсын зохицуулалтын эрхзүйн орчны судалгаанаас авч үзвэл макро түвшин дэх салбарын зайлшгүй байх хуулиуд батлагдан хүчинтэй үйлчилж байгааг, зохицуулалттай санхүүгийн салбар бүрийн журам, зааврууд батлагдан хүчинтэй үйлчилж байгааг харж байна.
- Зах зээлийн зохицуулалтын гол хуулиудын харьцуулсан үнэлгээнүүдээс авч үзвэл манай улсын хувьд хуулиудыг боловсруулан, хэрэгжиж явж байгаа нь харагдаж байгаа юм. Харин уг хуулиудын хэрэгжилтийн үнэлгээг хийх нь чухал байна. Мөн судалгааны багаас одоо хэрэгжиж үйлчилж байгаа хуулиудад хэрэглэгчийн

хамгаалах заалтууд, гадаад харилцаа болон аутсорсинг ашиглан үйл ажиллагаагаа сайжруулах, технологийн зохицуулалт гэх мэт заалтуудыг бусад улсын хуулиудыг судлан шинэчлэн өөрчлөх нь зүйтэй гэж дүгнэлээ.

- Харин байгууллагын түвшинд комплайнсын нэгж заавал байх ёстойг, комплайнсын бодлого, төсөвтэй зайлшгүй байх шаардлагатайг 2022 оноос дагаж мөрдөж байгаа ба СЗХ-ноос комплайнстай холбоотой суурь ойлголтууд, комплайнсын байгууллага дээрх удирдлагын талаарх сургалтуудыг идэвхтэй явуулж байна.

БҮЛЭГ 3: СЗХ-НЫ ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАР ДАХЬ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН КОМПЛАЙНСЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ НЬ

3.1 Санхүүгийн байгууллагын комплайнсын тогтолцооны өнөөгийн байдлын судалгаа

Санхүүгийн салбар дахь тогтвортой байдлыг хангахын тулд засаглал, эрсдэлийн удирдлагаас гадна комплайнсын удирдлагыг хэрэгжүүлэх олон улсын тэргүүн туршлага байна. Энэхүү судалгаа нь манай улсын Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбар дахь комплайнсын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, цаашид салбарын хэмжээнд тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлсон анхны судалгаа болох юм. Санхүүгийн байгууллагуудад салбарын хууль, эрх зүйн орчны өөрчлөлтөд нийцүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, зах зээлийн хурдацтай өөрчлөлттэй уялдуулан комплайнсын дүрэм, журмаа боловсруулах, хэрэгжилтийг хангах, хяналтын тогтолцоог бүрдүүлэх зэрэг сорилт бэрхшээлүүд үүсдэг.


Судалгааны зорилго: Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай санхүүгийн салбарын комплайнсын тогтолцооны өнөөгийн байдлыг тодорхойлох, салбарын комплайнсын тогтолцоог хөгжүүлэхэд санал, дүгнэлт гаргах.

Судалгааны арга зүй: “Ernst&Young” үнэлгээний байгууллагын 2021 онд хийсэн “Комплайнсын эрсдэлийг үнэлэх” судалгаа болон онолын судалгаанд үндэслэн нийт 5 бүлэг, 35 асуулт бүхий судалгааны асуулгыг 2023.06.20-2023.08.21 хооронд даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ, хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК) болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ) байгууллагуудаас санал асуулга хэлбэрээр авав. Судалгааны асуулгын агуулга нь дараах бүтэцтэй. Үүнд:

1. Засаглал, эрсдэл, комплайнсын удирдлагын тогтолцоо
2. Комплайнсын хамрах хүрээ, соёл
3. Комплайнсын засаглал
4. Комплайнсын үйл ажиллагаа, бодлого
5. Дижитал хэрэглээ, сургалт гэсэн бүлгүүд багтана.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбарын 77 хувь нь буюу 145 байгууллагаас 111 нь хамрагдав. Үүнээс итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ 66, Хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК) 18, Даатгагч 16, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (цаашид ВХҮҮ гэх) 11 байгууллага судалгаанд хамрагджээ.

Зураг 0.1 Судалгааны хамрах хүрээ



Судалгааны үр дүнгээс судалгаанд хамрагдсан албан тушаалтнуудыг авч үзвэл, гүйцэтгэх захирал 29 хувь, эрсдэл хариуцсан захирал, мэргэжилтэн 13 хувь, комплайнс хариуцсан захирал, мэргэжилтэн 22 хувь, санхүү 9 хувь, хууль 4 хувь, дотоод аудитор 9 хувь, бусад чиг үүрэг хариуцсан мэргэжилтнүүд 8 хувь гэсэн бүтэцтэй байна. Судалгаанд хамрагдсан байгууллагын дийлэнх буюу 53 хувь нь 6-15 жил ажилласан, 30 хувь нь 5 хүртэл, үлдсэн хэсэг нь 16-аас дээш жил ажилласан туршлагатай байна. Харин ажилтны тоогоор авч үзвэл 50 орчим хувь нь 10 хүртэл, гуравны нэг нь 50 хүртэл, 20 орчим хувь нь 50 дээш ажилтантай байна. Үйл ажиллагаа явуулсан туршлага, ажилтны тооноос хамааран комплайнсын удирдлагыг хэрэгжүүлдэг бүтэц, зохион байгуулалт харилцан адилгүй байна.

3.2 Судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан нийт 111 байгууллагаас засаглалын тогтолцоо бүрдсэн гэж хамгийн их хувь нь буюу 64 хувь, үүний дараа комплайнсын тогтолцоо бүрдсэн гэж 59 хувь, хамгийн бага буюу 56 хувь нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдсэн гэдэгтэй санал нийлжээ. ВХҮҮ байгууллагуудад зохицуулалтын шаардлагатай холбоотойгоор комплайнс хариуцсан алба нэгж эсвэл ажилтантай, холбогдох дүрэм журамтай байна гэж заасны дагуу комплайнсын тогтолцоо бусад салбартай харьцуулахад харьцангуй өндөр буюу 70 гаруй хувьд бүрджээ. Тиймээс комплайнсын тогтолцоог бүрдүүлэхэд зохицуулалтын шаардлагыг ВХҮҮ салбараас бусад салбарт тодорхой болгох хэрэгтэй гэж үзэж байна. Комплайнсын удирдлагын хөтөлбөр, төлөвлөгөөг нийт байгууллагуудын тал хувь нь боловсруулж, хэрэгжүүлдэг гэжээ. Комплайнсын хөтөлбөр, төлөвлөгөө нь комплайнсын тогтолцоо бүрдэх суурь хүчин зүйл бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд санхүүгийн болон хүний нөөцийн дутагдал голлон нөлөөлж байна гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдын 80 орчим хувь нь комплайнсын чиг үүрэг бүхий 1 ажилтантай, 15 хувь нь комплайнсын бие даасан нэгжтэй, үлдсэн хэсэг нь бусад чиг үүрэг хэрэгжүүлдэг тал давхар хариуцдаг болох нь судалгаанаас харагдаж байна. Санхүүгийн салбар дахь комплайнсын тогтолцоог бүрдүүлэх, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор СЗХ-оос энэ чиглэлийн сургалт, таниулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, гарын авлага болон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх нь санхүүгийн салбарт комплайнсын тогтолцоо бүрдэх, цаашид учрах эрсдэлээс сэргийлэх ач холбогдолтой юм. Санхүүгийн байгууллагуудын 80 орчим хувь нь ТУЗ-ийн түвшинд комплайнсын эрсдэлийг хэлэлцдэг тогтолцоотой гэж хариулсан нь санхүүгийн салбарт комплайнсын асуудлыг байгууллагын дээд удирдлагын түвшинд хэлэлцэж, ач холбогдол өгч байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан байгууллагууд комплайнсын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд учирч буй гол бэрхшээл нь хяналтын процессыг автоматжуулах, зохицуулалтын өөрчлөлтөд үйл ажиллагааг нийцүүлэх гэж үзжээ. Иймд байгууллагуудад тулгарч болох бэрхшээлийг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага тавих, хэрэгжилтийн үр дүнг тогтмол үнэлэх, тасралтгүй сайжрах тогтолцоог бүрдүүлэх нь үр дүнтэй юм. Ялангуяа шинээр

өөрчлөгдөж буй зохицуулалт, түүний мөн чанарыг оролцогч талуудад таниулах ажлыг зохион байгуулах хэрэгтэй юм.

Комплайнсын тогтолцоог сайжруулахад зөвлөх үйлчилгээ шаардлагатай эсэхийг тодруулахад нэгд, комплайнсын эрсдэлийг илрүүлэх арга зүй, технологи хөгжүүлэх, хоёрдугаарт, комплайнсын хяналтын арга зүй, гуравдугаарт, комплайнсын аудит, үнэлгээ хийх арга зүйг сайжруулахад гэж хариулжээ. Дээрх чиглэлд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах нь илүү үр дүнтэй гэж дүгнэлээ. Орчин үеийн практик туршлагаар комплайнсын эрсдэлийг удирдахад технологит суурилах чиг хандлага байгаа ба манай улсын хувьд ч мөн энэ чиг хандлага ажиглагдаж байна. Тиймээс технологийн оновчтой шийдлийг олох, хөрөнгө оруулалтын зардлыг бууруулахын тулд хамтарсан судалгаа хийх, оновчтой технологийг шийдлийг олох, мэдээллийг аюулгүй байдлыг хангах зэрэг арга хэмжээг авах нь салбарын хэмжээнд комплайнсын тогтолцоо бүрдэхэд чухал нөлөө үзүүлэх нэг хүчин зүйл болно. Асуулга судалгааны асуумжийг Хавсралт 1-ээр харуулав.

БҮЛЭГ 4: КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ НЬ

Хорооны зохицуулалтын салбар дахь байгууллагуудын комплайнсын эрсдэлийг үнэлснээр олон улсын стандартыг бүрэн мөрдөж ажилладаг эсэхээ тодорхойлох, цаашдаа анхаарч ажиллах шаардлагатай асуудлуудаа илрүүлэх, засч, сайжруулах, комплайнсын эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжуудыг байгууллагад бий болгоно.


4.1 Комплайнсын эрсдэлийн үнэлгээний аргачлалын онолын судалгаа

Комплайнсын эрсдэлийн үнэлгээ нь аюулыг тодорхойлох, эрсдэлийн түвшинд шинжилгээ хийх, эрсдэлийг бууруулахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатайг тодорхойлох, санаачилгыг хэрэгжүүлэх, үр нөлөөг үнэлэх зэрэг хэд хэдэн үе шаттай байдаг.


1. Эрсдэлийг тодорхойлох. Тухайн байгууллагад ямар зохицуулалтын хууль, дүрэм журам, стандарт хамаарахыг тодорхойлох бөгөөд гол үйл ажиллагаа, мэдээллийн систем зэргээс эхэлнэ. Үүний тулд байгууллага доторх бүх оролцогч талуудаас мэдээлэл, санал авах шаардлагатай болдог.
2. Болзошгүй эрсдэлийг үр дагавар болон нөлөөлөлд өртөх талуудыг харьцуулах. Байгууллагын үйл ажиллагаа, комплайнсын түвшин, эрсдэл зэргийг тодорхойлсны дараагаар тэдгээрийн үр дагавар болон нөлөөлөлд өртөх талуудыг зураглаж гаргах хэрэгтэй. Энэ нь байгууллага эрсдэлээ бууруулах стратегиа эхлүүлэх арга юм.
3. Хамгийн ноцтой эрсдэлийг эрэмбэлж, хяналтын арга хэмжээг тодорхойлох. Комплайнсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эсвэл одоо байгааг сайжруулах нь маш их ажиллагаатай байж болох ч бүх эрсдэлийг тодорхойлсны дараа үр дагаврын хамгийн ноцтой эрсдэлийг эхэлж шийдвэрлэх хэрэгтэй. (Танай байгууллагын хувьд одоо байгаа хяналтын процесс нь эдгээр эрсдэлийг шийдвэрлэхгүй байгаа шалтгаан, үүнийг хэрхэн шийдвэрлэж засах, ирээдүйд энэхүү зөрчлийг хэрхэн илрүүлэх талаар бодолцох хэрэгтэй)
4. Хяналтыг хэрэгжүүлэх, турших. Хяналтыг хэрэгжүүлж эхлэн турших нь чухал алхам бөгөөд үр дүнг шалгаж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, үгүй бол яагаад гэдгийг судлах хэрэгтэй.
5. Хяналтыг тогтмол дахин үнэлж, шаардлагатай бол шинэчлэх. Комплайнсын хөтөлбөр нь байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй явагдах нэг хэсэг байх ёстой бөгөөд бизнес өсөх тусам эрсдэл өөрчлөгддөг. Мөн үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомж, стандартууд ч өөрчлөгдөж байдаг. Хяналтыг тогтмол хийж, үйл ажиллагаа өргөжих, хууль тогтоомж өөрчлөгдөхөд эрсдэлүүдийг дахин үнэлэх хэрэгтэй.

Комплайнсын эрсдэлийн үнэлгээ нь тухайн бизнест хууль, дүрэм журам болон бусад стандартуудыг дагаж мөрдөхтэй холбоотой бусад асуудлуудтай тулгарч болох эрсдэлийг тодорхойлох явдал юм.

Зураг 0.1 Комплайнсын эрсдэлийн үнэлгээ



Зураг 0.2 Комплайнсын эрсдэлийн удирдлага



Байгууллагууд эрсдэлээ олж илрүүлэх, тэдгээрийн ач холбогдлыг үнэлэхийн тулд комплайнсын эрсдэлийн үнэлгээг хийх ёстой юм. Үнэлгээнд үндэслэн байгууллага нь аливаа эрсдэлтэй үйл ажиллагаагаа олж илрүүлж, асуудалтай байгаа үйл ажиллагааг сайжруулахын тулд комплайнсын хөтөлбөрөө сайжруулдаг. Компаниуд олон төрлийн үнэлгээ хийдэг боловч комплайнсын эрсдэлийн үнэлгээ нь тухайн бизнес нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд онцгой анхаарал хандуулдаг.

Зураг 0.3 Комплайнсын хамрах хүрээ



Комплайнсын эрсдэлийн үнэлгээ нь эрсдэлийг тодорхойлох буюу бизнес загвар болон хууль эрх зүйн, бизнесийн орчинтой холбоотой бий болж буй эрсдэлийн зураглалыг тодорхойлж, холбогдох эрсдэлийн үзүүлэлтүүдийг жинлэх, оноожуулах байдлаар эрсдэлийн үнэлгээг хийж, одоо байгаа эрсдэлийн түвшинд авах арга хэмжээнүүдийг сайжруулж, эрсдэлийг бууруулах үндсэн тогтолцоонд суурилдаг.

- Уламжлалт буюу суурь эрсдэл: Хэрэв байгууллагад үүнийг бууруулах хяналтын систем байхгүй бол байгууллагад учирч болох эрсдэлийн түвшин юм. Энгийнээр бол хяналтын өмнөх эрсдэл юм. Эрсдэлийн үнэлгээг хийснээр байгууллага

өөрийн эрсдэлийг ойлгож, эрсдэл учрахаас өмнө стратегидоо урьдчилан тусгаж өгөхөд тусалдаг.

- Үлдэгдэл буюу хяналтын дараах эрсдэл: Байгууллага одоо байгаа хяналтын системээ харгалзан үзэж эрсдэлээ үнэлсэн үеийн эрсдэлийн түвшин юм.

Байгууллагад тохиолдож буй эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлохын тулд үйл явц бүрийн эрсдэлийн түвшинг үнэлж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн зохих арга хэмжээг санал болгож, эрсдэлийг илрүүлэх, хэрэгжүүлэхээс урьдчилан сэргийлэх хяналтыг бий болгох шаардлагатай юм.

2005 онд Базелийн хорооноос комплайнсын эрсдэлийг “Байгууллага өөрийн үйл ажиллагаатай холбогдох хууль, дүрэм журам, зохицуулах байгууллагын стандарт, түүний үйл ажиллагаанд мөрдөгдөх ёс зүйн хэм хэмжээг мөрдөөгүйгээс бий болох хууль эрх зүйн шийтгэл, санхүүгийн алдагдал, нэр хүндээ алдах эрсдэл” гэж тодорхойлсон.

Комплайнсын эрсдэлийн үнэлгээг дараах алхмуудаар хийнэ гэж тодорхойлсон. Үүнд:

- Нөхцөл байдлын шинжилгээ. Байгууллагад нөлөөлж болох гадаад, дотоод хүчин зүйлийг шинжлэх. Жишээлбэл, компанийн бүтэц, өмчлөл, ажилчдын тоо, байгууллагын үйл ажиллагаа эсвэл холбогдох дүрэм, журам зэрэг асуудлыг авч үзэх ёстой.
- Эрсдэлийг тодорхойлох. Тухайн байгууллагад тохиолдож болох эрсдэлийн жагсаалтыг гаргах юм.
- Эрсдэлийн шинжилгээ. Эрсдэл тус бүрийн магадлал, нөлөөллийг шинжлэх нь хамгийн сайн хувилбар юм. Магадлалын хүрээнд эрсдэлийн тохиолдож болох магадлалд шинжилгээ хийх бол нөлөөллийн тухайд нэр хүндэд нөлөөлөх, хууль эрх зүйн хувьд ямар хариуцлага хүлээх гэх мэт нөлөөллийг шинжилнэ.
- Эрсдэлийн үнэлгээ хийх. Эрсдэлийн үнэлгээгээр хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн чиглэлийг тодорхойлдог. Эрсдэлийн үнэлгээгээр өндөр түвшинд гарсан эрсдэлд гол анхаарлаа хандуулах гэх мэт нөөцийн хуваарилалтад анхаарах боломжийг олгодог.
- Эрсдэлийг удирдах. Энэ үе шатанд тодорхойлсон эрсдэлийг хэрхэн шийдвэрлэх талаар шийдвэр гаргадаг. Жишээлбэл эрсдэлээс зайлсхийх, магадлал болон нөлөөллийг бууруулах хяналтыг бий болгох, эрсдэлийг шилжүүлэх гэх мэт.
- Хянах. Энэ үе шат нь хяналтыг үр дүнтэй болгох эсвэл байгууллагын нөхцөл байдалд тодорхойгүй, шинэ эрсдэл үүсгэж болзошгүй өөрчлөлтийг илрүүлэх зорилготой байх ёстой.

Санхүүгийн байгууллага дахь комплайнсын эрсдэлийн үнэлгээний хөтөлбөр

Комплайнсын эрсдэлийн үнэлгээний хөтөлбөрийг дараах үндсэн алхмуудаар боловсруулдаг.

- Эрсдэл болон аливаа зөрчлийг холбогдох дүрэм, журмын хамт бэлтгэх
- Эрсдэл болон аливаа зөрчлийг холбогдох бодлого, журамтай харьцуулж бодит болон болзошгүй алдаа, дутагдлыг тэмдэглэх

3. Хяналт, шалгалтын үндсэн дээр буурсан болон бууруулах боломжтой эрсдэлүүдийг үнэлэх
4. Эрсдэлийг бууруулах, холбогдох алдаа дутагдлыг засч сайжруулах төлөвлөгөө боловсруулах

Эрсдэлийн бүртгэлийг бэлтгэх. Эхний алхам бол байгууллагын үйл ажиллагаа болон үйлчлүүлэгчдийн эрх ашигт эрсдэл үүсгэж болзошгүй холбогдох хууль, журам, ашиг сонирхлын зөрчил болон бусад асуудлуудыг (уламжлалт эрсдэл) тодорхойлох ёстой юм. Энэ алхам нь байгууллага уламжлалт эрсдэлүүдээ тодорхойлох, дүрэм, журмын иж бүрэн шинжилгээ хийх чухал алхмуудын нэг юм.

Уламжлалт болон суурь эрсдэлийг тодорхойлох эх сурвалжуудад дараах зүйлс орно. Үүнд:

- Комплайнсын мэдээлэл (хяналт, ажиглалт, шалгалтын үр дүн)
- Зөрчил, дотоод хяналт шалгалтын мэдээлэл (аудитын дүгнэлт болон бусад дотоод шалгалтын үр дүн)
- Хөндлөнгийн хяналт (хяналт бүхий байгууллагуудын хийсэн хяналт, шалгалтын дүгнэлт)
- Харилцагчийн мэдээлэл (хэрэглэгчдээс ирсэн гомдол гэх мэт)
- Байгууллагын мэдээлэл (ашиг, алдагдлын мэдээлэл, бүтээгдэхүүн үйлчилгээний асуудал гэх мэт)
- Хууль эрх зүйн мэдээлэл (дүрэм, журмын өөрчлөлт, зохицуулалтын гол чиглэл, тэргүүлэх чиглэл, аливаа шийтгэл торгууль авсан эсэх)

Уламжлалт эрсдэлийг тодорхойлохдоо эрсдэлүүдийн тоон болон үр нөлөөллийг асуусан асуулга байж болох бөгөөд эдгээр асуулгуудыг холбогдох экспертүүдээс авч болно.

Холбогдох бодлого, хууль, журам, хяналтуудын хооронд бий болж буй зөрчилдөөн болон эрсдэлийн зураглал гаргах. Дараагийн алхам бол тодорхой эрсдэлүүдийг буюу уламжлалт эрсдэлүүдийг тодорхойлох юм. Одоо хэрэгжиж буй хяналт, эрсдэлийг тодорхойлох бөгөөд хяналтын процесс нь үр дүнтэй байдаг эсэх (хяналтын процессын найдвартай байдал, хяналтад хамрагддаг нэгж, хяналтаас зугтах боломж байдаг эсэх), хяналтын систем үр дүнтэй ажилладаг эсэх (практикт хэр сайн хэрэгждэг, үндсэн бодлог журмынхаа дагуу ажилладаг эсэх, хяналтын үнэлгээг хийдэг эсэх) талаар асууж тодорхойлох боломжтой.

Эрсдэлийг эрэмбэлэх. Дээрх хоёр алхамд хийгдсэн шинжилгээнд үндэслэн 1) комплайнсыг хаана төвлөрүүлэх, хаана анхаарал илүү хандуулах ёстойг үнэлэх, 2) эдгээр эрсдэлүүдийг эрэмбэлэх хэрэгтэй. Эрсдэлийг үнэлэхдээ заавал бага, дунд, сайн гэх мэт үнэлгээний системийг ашиглах шаардлагагүй бөгөөд ерөнхийдөө үр дүнтэй үнэлгээний систем нь ач холбогдолтой дүгнэлтүүд, уялдаа холбоотой, сайн баримтжуулсан үндэслэл суурилсан байх ёстой юм.

Засварлах, төлөвлөгөө боловсруулах. Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн алдаа дутагдал, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах ёстой юм. Төлөвлөгөө боловсруулахдаа тухайн хугацаанд бодитоор юу хийж болох талаар бодитой хандах нь маш чухал. Хэрэв

тухайн төлөвлөгөө болон дүрэм, журмыг дагаж мөрдөх эсэх нь баталгаатай биш л бол хатуу зохицуулалт, дүрэм, журмыг гаргаж болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Эрсдэлийн үнэлгээ хийх хугацаа. Эрсдэлийн үнэлгээг хийхийг заасан тодорхой хугацаа байдаггүй бөгөөд гол нь эрсдэлийн үнэлгээ нь тогтмол хийгддэг байх ёстой юм. Аливаа болзошгүй үйл явдал (бизнесийн шинэ салбарт орох, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах, дотоод асуудал үүсэх, хууль эрх зүйн томоохон өөрчлөлт орох зэрэг)-ын эрсдэл, зөрчлийг үнэлж, зөрчлийг арилгах арга хэмжээ бий эсэхийг шалгах хэрэгтэй.

Ёс зүйн гажуудлаас үүсэх эрсдэл. Комплайнсын эрсдэлийн үнэлгээг үр дүнтэй байлгахын тулд санаатай болон санамсаргүй алдаа, ёс зүйгүй үйлдэлтэй холбоотой эрсдэлийг авч үзэх ёстой юм. Үйлчлүүлэгчид болон байгууллагад сонирхлын зөрчил үүсгэх, зах зээлийн шударга бус байдалд нөлөөлөх, байгууллагын нэр хүнд болон санхүүгийн эрсдэлийг нэмэгдүүлэх ажилтнуудын аливаа үйлдэл, эс үйлдэл юм. Энэхүү эрсдэлийг албан журмын бодлого, хяналтаар бус зан үйлдэл, соёлын хүчин зүйлсүүдэд 1) байгууллагын соёл, 2) ашиг сонирхлын зөрчил (бизнес загвар болон стратегиас үүдэлтэй), 3) хүмүүсийн эрсдэл (ялангуяа шагнал урамшуулал, бонус зэрэг) анхаарал хандуулах хэрэгтэй.

Дээрх эрсдэлээс үүдэлтэйгээр уламжлалт эрсдэлийг тодорхойлох. Зан үйлийн эрсдэлээс үүдэлтэйгээр байгууллагын уламжлалт эрсдэлийг тодорхойлохын тулд байгууллагын бизнес загвар, тодорхой чиглэл эсвэл хэлтэс хамаарах зөрчлийн үр дүнд үүсч болох дотоод, гадаад зөрчилдөөнийг үнэлэх ёстой юм. Жишээлбэл байгууллага болон үйлчлүүлэгч хоорондын сонирхлын зөрчил (бусад үйлчлүүлэгчдээсээ илүү нэмэлт төлбөр авах г.м), харилцагчид хоорондын сонирхлын зөрчил (өөр хоорондоо өрсөлдөж буй олон үйлчлүүлэгчтэй байх г.м), ажилтан болон үйлчлүүлэгч хоорондын сонирхлын зөрчил (бонус, нэмэлт урамшуулалтай холбоотойгоор үйлчлүүлэгчид тодорхой нэмэлт ажил гүйлгээ хийхийг санал болгох г.м), байгууллага болон ажилтан хоорондын сонирхлын зөрчил (ажилтан байгууллагатай ашиг сонирхлын зөрчилтэй өөр ажил эрхлэх г.м) зэрэг зөрчлүүд байж болох юм.

Бодлого, хяналт, эрсдэлийн зураглал. Засаглал ба эрсдэлийн удирдлагын хувьд зан үйлийн эрсдэлийг бууруулахын тулд 1) хяналт, шалгалтыг нэмэгдүүлэх, 2) албан ёсны журам, хурлын тэмдэглэлийг сайжруулах, 3) тогтмол сургалт, шалгалтыг хийдэг байх, 4) ёс зүйн дүрэм, журмыг гаргах, 5) ёс зүйгүй үйлдэл гарсан тохиолдолд сахилгын арга хэмжээг авах албажуулсан процесстэй байх зэрэг арга хэмжээг авах хэрэгтэй.

Комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийх алхам (Compliance Engineering International , 2020)

1-р үе шат: Өгөгдөл, мэдээлэл цуглуулах

Алхам 1. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, ажилчид, бизнесийн орчин

Санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтыг гаргах бөгөөд энд зээл, даатгал, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, татварын төлөвлөгөө зэрэг бүхий л мэдээллийг багтаасан байна.

Алхам 2. Хяналт болон систем

Компаний бодлого, процедур, систем зэрэгт үндэслэн ямар төрлийн байгууллага болохыг тодорхойлно. Дараах зүйлс дээр илүү ач холбогдол өгөх шаардлагатай. Үүнд:

- Байгууллагын удирдлага, хяналттай холбоотой танилцуулгуудыг авах
 - Комплайнстай холбоотой бодлого, процедур
 - Үйл ажиллагаа нь төвлөрсөн эсвэл төвлөрсөн бус эсэх
 - Үйл ажиллагаа нь автомат уу эсвэл автомат бус гар аргаар явагддаг уу
 - Бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж буй орчин, байршил
 - Бүтээгдэхүүн, үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчдийн орчин, байршил
 - Ажилчдын эргэлт буюу хүний нөөцийн урсгал
 - Комплайнсыг хэрэгжүүлэх сургалт, төлөвлөгөө
 - Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөө бий эсэх
 - Өнгөрсөн жилд үндсэн үйл ажиллагаа явуулж буй чиглэлд хэр зэрэг өөрчлөлт орсон эсэх
 - Мэдээллийн системийн удирдлага ямар байгаа зэрэг
- Танилцуулга, мэдээллийг нэгтгэх

Алхам 3. Хууль, эрх зүйн зохицуулалт

Байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээ нь холбогдох анхан шатны хууль, дүрэм, журамтай нийцэж байгаа эсэхийг хянаж, дүгнэнэ.

2-р үе шат: Уламжлалт болон суурь эрсдэлийн шинжилгээ

Алхам 1. Юуны өмнө тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зохицуулагч байгууллагын комплайнстай холбогдох хууль, журам, голлох журам, тусгай зохицуулалтын журам бий эсэхийг мэдэх хэрэгтэй. Дараах эрсдэлийн зүйлүүдийг анхаарч үзэх хэрэгтэй. Үүнд:

- Бага
 - Ямар нэгэн торгууль, шийтгэл байхгүй эсвэл маш бага
 - Одоогийн зохицуулалтын тэргүүлэх чиглэл биш (голлох эрсдэлтэй бүлэг, улс орны хэмжээнд анхаарч үзэж байгаа салбар, үйл ажиллагаа мөн эсэх)
- Дунд
 - Ямар нэгэн торгууль, шийтгэлд хүргэж болзошгүй (дунд зэргийн)
 - Одоогоор зохицуулагчдын хувьд дунд зэргийн анхаарал хандуулж байгаа эсвэл тэргүүлэх чиглэл
 - Бүрэн бус зохицуулалттай, дунд зэргийн төвөгтэй нөхцөл байдалд байгаа
 - Хяналт бүхий байгууллагаас бага зэргийн алдааг тэмдэглэж, сануулсан
- Өндөр
 - Их хэмжээний торгууль, шийтгэлд хүргэж болзошгүй
 - Одоогоор зохицуулагчид өндөр ач холбогдол өгч байгаа
 - Зохицуулалтын бүрэн бус удирдамж бүхий, маш нарийн төвөгтэй шаардлагатай
 - Холбогдох алдаа, зөрчил үүссэн

Алхам 2. Нэр хүндийн эрсдэл

Олон нийт, нийгмийн түвшинд комплайнсын бус асуудал, эрсдэл бий эсэхийг үнэлэх.

- Бага
 - Харилцагч, үйлчлүүлэгчид итгэдэг, эргэлздэггүй эсвэл маш бага эргэлзээтэй байдаг
- Дунд
 - Харилцагч, үйлчлүүлэгчид дунд зэргийн эргэлзээтэй байдаг
- Өндөр
 - Харилцагч, үйлчлүүлэгчид ихээхэн эргэлзээтэй, аливаа алдагдалд орох эсэх хүлээлттэй

Алхам 3. Уламжлалт болон суурь эрсдэл

Нэг болон хоёрдугаар алхамд тодорхойлсон эрсдэлүүдийг ашиглан бүтээгдэхүүн үйлчилгээ тус бүр дээр тооцоолно.

Хүснэгт 0.1 Уламжлалт эрсдэл тооцох матриц

Хууль эрх зүйн эрсдэл (өндөр)	Дунд	Өндөр	Өндөр
Хууль эрх зүйн эрсдэл (дунд)	Бага	Дунд	Өндөр
Хууль эрх зүйн эрсдэл (бага)	Бага	Бага	Дунд
Уламжлалт болон суурь эрсдэл	Нэр хүндийн эрсдэл (бага)	Нэр хүндийн эрсдэл (дунд)	Нэр хүндийн эрсдэл (өндөр)

3-р үе шат: Үлдэгдэл эрсдэлийн шинжилгээ

Алхам 1. Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл нь хэдийгээр субъектив шинж чанартай боловч дор хаяж хоёр хүнтэй маш сайн ярилцлага хэлбэрээр тодорхойлох хэрэгтэй гэж үздэг. Үүнд дотоод хяналт байгаа эсэх, дагаж мөрддөг журмын биелэлт, төвлөрлийн зэрэг, хүний алдааг арилгах автоматжуулалтын түвшин, хүний нөөцийн эргэлт, зохих сургалт хөтөлбөр зэргийн талаар мэдээллийг авдаг.

- Бага
 - Комплайнсын дагаж мөрдөх журам, дотоод хяналт зэрэг байдаг
 - Төвлөрсөн
 - Хэсэгчилсэн эсвэл бүрэн автоматжуулсан
 - Ажилтны эргэц бага
 - Хангалттай сургалтад хамрагдсан
 - Үйлчлүүлэгч, харилцагчид нь байнгын оршин суугч
 - Үйлчлүүлэгч, харилцагчидтай биечлэн уулздаг
- Дунд
 - Дотоод хяналт, үйл ажиллагаа, журам, журмын хэрэгжилт бага зэрэг сул
 - Хэсэгчилсэн төвлөрсөн бус
 - Ажилтны эргэц дунд зэрэг
 - Сургалтыг заримдаа хийдэг (ахисан түвшний биш, суурь сургалтууд)
 - Данс нээхдээ биечилж уулздаггүй боловч гүйлгээг зайнаас хийдэггүй

- Үйлчлүүлэгч байнгын оршин суугч
- Өндөр
 - Дотоод, хяналт, журам сул эсвэл огт байхгүй
 - Төвлөрсөн бус
 - Автоматжаагүй
 - Ажилтны эргэц өндөр
 - Сургалт хийдэггүй
 - Биечилж данс нээдэггүй
 - Үйлчлүүлэгч байнгын оршин суугч биш мөн олон төрлийн бизнес эрхэлдэг

Алхам 2. Эрсдэлийн магадлал

Түүхэн өгөгдөлд үндэслэн өмнө нь гарч байсан эрсдэлийн магадлалыг үнэлнэ.

- Шалгалт, аудит, шалгалтын үр дүн
 - Бага – Сүүлийн шалгалтаар алдаа илэрсэн
 - Дунд – Сүүлийн шалгалтаар бага зэргийн алдаа илэрсэн
 - Их – Сүүлийн шалгалтаар мэдэгдэхүйц алдаа илэрсэн
- Хууль эрх зүйн өөрчлөлт
 - Бага – Сүүлийн шалгалтаас хойш өөрчлөлт ороогүй
 - Дунд – Сүүлийн шалгалтаас хойш бага зэргийн өөрчлөлт орсон
 - Их – Сүүлийн шалгалтаас хойш мэдэгдэхүйц өөрчлөлт орсон
- Бүтээгдэхүүн үйлчилгээний өөрчлөлт
 - Бага – Сүүлийн шалгалтаас хойш өөрчлөлт ороогүй
 - Дунд – Сүүлийн шалгалтаас хойш бага зэргийн өөрчлөлт орсон
 - Их – Сүүлийн шалгалтаас хойш мэдэгдэхүйц өөрчлөлт орсон

Алхам 3. Үлдэгдэл эрсдэл

Нэг болон хоёрдугаар алхамд тодорхойлсон эрсдэлүүдийг ашиглан бүтээгдэхүүн үйлчилгээ тус бүр дээр тооцоолно.

Хүснэгт 0.2 Үлдэгдэл эрсдэл тооцох матриц

Үйл ажиллагааны эрсдэл (өндөр)	Дунд	Өндөр	Өндөр
Үйл ажиллагааны эрсдэл (дунд)	Бага	Дунд	Өндөр
Үйл ажиллагааны эрсдэл (бага)	Бага	Бага	Дунд
Үлдэгдэл эрсдэл	Эрсдэлийн магадлал (бага)	Эрсдэлийн магадлал (дунд)	Эрсдэлийн магадлал (өндөр)

4-р үе шат: Нийт эрсдэлийн шинжилгээ

Алхам 1. Нийт эрсдэл

Энэ алхамд тооцоолсон эрсдэлийг дараах байдлаар эрэмбэлж болно. Үүнд:

Хүснэгт 0.3 Нийт эрсдэл тооцох матриц

Уламжлалт эрсдэл (өндөр)	Дунд	Өндөр	Өндөр
Уламжлалт эрсдэл (дунд)	Бага	Дунд	Өндөр
Уламжлалт эрсдэл (бага)	Бага	Бага	Дунд
ЭРСДЭЛ	Үлдэгдэл эрсдэл (бага)	Үлдэгдэл эрсдэл (дунд)	Үлдэгдэл эрсдэл (өндөр)

Бүтээгдэхүүн, үйлчилгээ, эсвэл үйл ажиллагааны чиглэл тус бүр дээр бага, дунд, зэрэг гэсэн эрэмбэ гарах юм.

Алхам 2. Удирдлагын уян хатан байдал болон комплайнсын эрсдэл

Байгууллагын удирдлагын эрсдэлд хандах хандлагыг авч үзэх хэрэгтэй бөгөөд эрсдэл өндөр байсан ч удирдлага түүнийг хүлээн зөвшөөрөх тохиолдол байдаг бол хяналтыг маш сайн тавьдаг байх хэрэгтэй.

Алхам 3. Эрсдэлийн чиглүүлэгч

Цаашид авч үзэх эрсдэлийн чиглэл, арга хэмжээнүүдийг чиглэл тус бүрд авч үзэх хэрэгтэй. Үүнд:

- Өсөх хандлагатай: Удирдлага нь илүү их хяналт, шалгалтыг нэмэгдүүлэх замаар нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай.
- Тогтвортой: Нэмэлт арга хэмжээ авах шаардлагагүй
- Буурах хандлагатай: Удирдлага нь хяналтыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, сайжруулах талаар арга хэмжээ авч болно.

Банкны салбар дахь комплайнсын эрсдэлийн үнэлгээний PRISM аргачлал

Энэхүү судалгааны ажлаар Partial Risk Map буюу PRISM үнэлгээний аргачлалыг ашиглан банкны салбарт ашиглагдах комплайнсын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулсан байна.

Комплайнсын эрсдэлийн удирдлага нь байгууллагын эрсдэл даах чадварыг тодорхойлох, эрсдэлийн түвшинг тогтооход оршино. Нэр хүндийн эрсдэлийг багтаасан комплайнсын эрсдэл нь банкны салбарын стратегийн эрсдэлийг бууруулж чаддаг гэж үздэг байна. Комплайнсын эрсдэл нь байгууллагад комплайнсын мэргэжилтэн дутмаг, бүрэн бус үзүүлэлтүүд, гуравдагч талаас хамаарсан нуугдмал эрсдэлүүд, хууль эрх зүйн хурдтай өөрчлөлтүүд зэрэг өргөн хүрээний асуудлуудаас хамаардаг.

Эрсдэлийн үнэлгээний аргачлалын хамгийн түгээмэл хоёр арга нь олон талт шийдвэр гаргах арга (MCDM) болон нарийн төвөгтэй асуудлуудыг илүү нарийвчлан дүрсэлдэг программын аргууд юм. Мөн олон салбарт түгээмэл ашиглагддаг нэг аргачлал нь эрсдэлийн матрицын арга болон Failure Mode and Effect Analysis (FMEA) аргачлал бөгөөд PRISM арга нь ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй хэсэгчилсэн эрсдэлийг үнэлэхэд илүү чиглэдэг байна.

Олон улсын стандарт ISO нь 2021 онд ISO19600:2014 стандартыг орлох шинэ стандарт “Комплайнсын удирдлагын систем ISO 37301:2021” стандартыг гаргасан. Энэхүү стандартаар дагаж мөрдөх удирдамжийг заавал мөрдөх шаардлага болгон өөрчилсөн байна.



Комплайнсыг хэрэгжүүлдэг байгууллага бүр комплайнсын эрсдэлийн үнэлгээг боловсруулахдаа өөрсдийн хэрэгцээ шаардлага болон онцлогт тохирсон аргачлалыг боловсруулах шаардлагатай. Байгууллагууд комплайнсын эрсдэл боон удирдах аргачлалаа тодорхойлноор үйл ажиллагаагаа сайжруулж, комплайнсын зөрчлийн тоо болон эрсдэлтэй байдлыг бууруулж чаддаг.

Эрсдэлийн үнэлгээний аргачлалд тулгуурлан эрсдэлээ тодорхойлж, эрсдэлийг тооцох нь эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд хамгийн гол зүйл бөгөөд эрсдэлийг тодорхойлох гэдэг нь эрсдэлийн шинж чанар, түүний нөлөөлөл, учир шалтгааныг тодорхойлох юм. Эрсдэлийн матриц нь банкны салбарт түгээмэл ашиглагддаг эрсдэлийн үнэлгээний аргачлал бөгөөд тохиолдох магадлал болон нөлөөлөл гэсэн 2 гол хүчин зүйлийг ашигладаг.

Эрсдэлийн матрицтай харьцуулахад FMEA аргачлал нь 3 хүчин зүйл (тохиолдох магадлал, нөлөөлөл, илрүүлэлт)-ийг ашигладаг. FMEA аргачлал нь бүтээгдэхүүн үйлчилгээ болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн эрсдэлийг бууруулах зорилготой юм. PRISM нь эрсдэлийн үнэлгээний шинэ аргачлал бөгөөд FMEA аргачлалтай төстэй бөгөөд бусад аргачлалуудтай хослуулсан загвар юм.

Алхам 1	Алхам 2	Алхам 3
Үнэлгээнд бэлдэх	Харьцуулалтын хуудас бэлтгэх	Шинжилгээ хийх
Удирдах зөвлөлийн гишүүдэд зорилгоо танилцуулж, санал авах	Тохиолдох магадлал, нөлөөлөл, илрүүлэх боломжийг тус тусад нь үнэлэх хуудас бэлтгэх	Сонголтуудыг тус тусад нь тодорхойлж, тогтвортой байдлын шинжилгээ хийх
Алхам 4	Алхам 5	Алхам 6
Гарсан үр дүнгүүдийн хоорондоо төстэй байдлыг шинжлэх	Үнэлгээг нэгтгэх, жинлэх	PRISM загвар
Корреляцийн коэффициентэнд үндэслэн асуудлын шинж чанарыг тодорхойлох	Тохиолдох магадлал, нөлөөлөл, илрүүлэх боломж	PRISM загварыг бүх тохиолдолд тооцоолно. $A(m)$, $M(m)$, $S(m)$ PRISM бүтцэд суурилана
Алхам 7	Алхам 8	Алхам 9

Тохиолдол бүрийн PRISM дугаарлах	Тохиолдол бүрийн зэрэглэлийг тогтоож, төстэй байдлын шинжилгээ хийх	Эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл
Тохиолдол бүр PRISM функцийн дагуу илүү олон PRISM дугаарлалттай байна	Төстэй байдлын шинжилгээнд үндэслэж шинжсэчийн дүгнэлтийг эхний байдлаар гаргаж болно	Тохиолдол бүрийн зэрэглэлд үндэслэн тэргүүлэх чиглэлүүдийг тогтоох

Эхний алхам бол харьцуулж болохуйц элементүүдийн багцыг бүрдүүлэх бөгөөд экспертүүдийн фокус бүлгийг байгуулж болох юм.

Хоёрдугаар алхам бол тохиолдох магадлал, нөлөөлөл, илрүүлэлтийн үнэлгээний хүчин зүйлсийг тус тусад нь харьцуулах хүснэгтүүдийг бэлтгэнэ. Хүчин зүйлсүүдийн тоог n гэж тэмдэглэвэл дараах тэгшитгэл дээр үндэслэн p тооны хослолыг үүсгэж болно.

$$p = n(n-1)/2$$

Гуравт экспертүүдийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, тогтвортой байдлыг нь шалгана. Тогтвортой байдлын түвшинг дараах тэгшитгэлээр тооцож болно.

$$K = 1 - d/d_{max}$$

d_{max} нь загварт үл нийцэх боломжит хамгийн их тоо

$$\text{Сондгой } n: d_{max} = (n^3 - n)/24 \quad \text{Тэгш } n: d_{max} = (n^3 - 4n)/24$$

d нь тодорхой хослолуудын харьцуулалтын загварт үл нийцэх тоог илэрхийлнэ.

$$d = (n(n-1)(2n-1))/12 - \sum a_i/2$$

a_i нь тухайн i элемент нь бусад элементүүдээс хэр олон давтамжтай тохиолдох магадлалтайг илэрхийлнэ.

Хи квадратын тархалтын ач холбогдлын тестэд үндэслэн d тоо нь харьцуулалтын загварт санамсаргүй эсвэл системчилсэн зөрчилтэй байгаа эсэхийг тодорхойлж болно. Хи квадрат тархалт нь чөлөөний зэргийг (DF) тооцоход зориулагдсан ба дараах тэгшитгэлээр тооцно.

$$DF = (n(n-1)(n-2))/(n-4)^2$$

Хи квадрат үнэлгээг дараах тэгшитгэлээр тооцно.

$$\chi^2 = 8/(n-4) \{ 1/4(3/n) - d + 1/2 \} + DF$$

Дөрөвдүгээр алхам нь тохиолдол бүрийн ижил төстэй байдлыг шалгах бөгөөд ижил төстэй байдлыг шалгасны үндсэн дээр үр дүнгүүдийг нэгтгэж үнэлгээг хийх боломжтой эсэхийг шийдэх юм. Хоёр тохиолдлын хувьд ижил төстэй байдлын түвшинг шалгахын тулд корреляцийн шинжилгээг ашиглаж болох бол хоёроос дээш үед нэгтгэх эсвэл татгалзах аргачлалыг ашиглаж болох юм. Энэхүү судалгаанд 2 зэрэглэлийн

шинжилгээнд Spearman-ы тооцоолол, хоёроос дээш зэрэглэлийн шинжилгээнд Kendall's W тооцооллыг үндэслэн загварыг гаргасан байна.

Spearman зэрэглэлийн корреляцийн коэффициент нь -1-ээс 1-ийн хооронд байх ба зэрэглэлүүд хоорондоо ижилхэн тохиолдолд +1 коэффициент, хоорондоо эсрэг тохиолдолд -1 коэффициенттэй байна. Хэрэв хоорондоо хамааралгүй тохиолдолд 0 коэффициенттэй байна. Kendall's W коэффициент нь 0-ээс 1-ийн хооронд байх ба зэрэглэлүүд хоорондоо ижилхэн тохиолдолд 1 үнэлгээ, хоорондоо эсрэг тохиолдолд 0 үнэлгээтэй байна. Хоёр аргачлалын хувьд 5 хувийн итгэх магадлал дээр үнэлгээг хийхийг санал болгодог байна.

Хэрэв зэрэглэлүүд хоорондоо ижил байгаа тохиолдолд тавдугаар алхам руу орох бөгөөд i элемент нь бусад элементүүдээс хэр олон давтамжтай тохиолдох магадлалтайг тооцоолох юм.

$$P_c = (c_i + (k/2)) / nk$$

Энд c_i нь матриц дахь тохиолдлын тоо, k нь экспертүүдийн тогтвортой байдлын түвшинг илэрхийлнэ.


Онолын хувьд c_i -н тохиолдох хамгийн өндөр магадлал C_1 , тохиолдох хамгийн бага магадлал C_2 хувьсагчуудыг тодорхойлох шаардлагатай.

$$cC_1 = (n-1)k$$

$$cC_2 = (n-1)0 = 0$$

Үр дүнгүүдийг C_1 болон C_2 утгуудыг ашиглан интервалыг тогтоох бөгөөд P_c утгыг u утга болгон хувиргана. Шугаман хувиргалт нь u утгыг сонгосон хэсэгт хувиргах боломжтой юм.

Тохиолдол тус бүрийг хамааруулан тохиолдох магадлал, нөлөөлөл, илрүүлэлтийн хүчин зүйлүүдийг зургаа дугаар алхамд тооцоолон PRISM загварт байршуулах боломжтой. PRISM аргачлал нь тохиолдлуудын хосолсон үнэлгээний хүчин зүйлүүдийн нийлбэр утгуудыг тооцдог ба m тохиолдлыг PRISM загварт $p(m) = p(o, s, d) = (o \otimes s, o \otimes d, d \otimes s)$ гэж тэмдэглэнэ.



Долдугаар алхамд $p(m)$ -н гурван утгын хамгийн их утгыг нь сонгох замаар тухайн тохиолдлуудын PRISM-г дугаарлаж болно. Үр дүнгийн үнэн байдлыг шалгахын тулд PRISM матриц дээр янз бүрийн босго утгуудыг ашиглан өөр өөр төрлийн (шугаман, гүдгэр, хотгор) үнэлгээг хийдэг.

$$A(m) = \max(o+s, o+d, d+s)$$

$$M(m) = \max(o \cdot s, o \cdot d, d \cdot s)$$

$$S(m) = \max(o2+s2, o2+d2, d2+s2)$$

$A(m)$ нь шугаман тэгшитгэлийн үр дүн, $M(m)$ нь гүдгэр тэгшитгэлийн үр дүн, $S(m)$ нь хотгор тэгшитгэлийн үр дүн бөгөөд үр дүнгүүдэд үндэслэн эрсдэлийг цаашид бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг ёс дүгээр алхмаас эхлүүлэх юм.

4.2 Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбар дахь комплайнсын эрсдэлийн үнэлгээний аргачлал

4.2.1 Комплайнсын эрсдэлийн үнэлгээний асуулга

Судалгааны асуулгыг олон улсын “The Wolfsberg Group”-ийн 2022-2023 оны банк ба санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зуучлагч байгууллагуудад зориулсан “Санхүүгийн гэмт хэрэг комплайнсын асуулга” эх сурвалжаас авч боловсрууллаа. Энэхүү асуулга нь ФАТФ-ын 40+9 зөвлөмжийн агуулгыг багтаан тухайн байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийж буй нь давуу тал болно. Санхүүгийн зуучлагч байгууллага болон зохицуулагч байгууллагын хоёр талын нууцын гэрээнд гарын үсэг зурж баталгаажсанаар асуулгыг авна. Асуулгыг бүрэн бөгөөд үнэн зөв, бүх салбар бизнесийн нэгжийг төлөөлж байгааг баталгаажуулан удирдах албан тушаал эрхэлж буй удирдлагын төлөөлөл эсвэл комплайнсын үйл ажиллагааг ахалж буй мэргэжилтэн гарын үсэг зурсан байна.

Асуултууд нь байгууллага санхүүгийн гэмт хэрэгт өртөх эрсдэлийн талаар бүрэн ойлголт, мэдээлэлтэй байгаа эсэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны бодлого, дүрэм журам, бэлэн байдал байгаа эсэх дээр үнэлгээ хийх зорилготой ба үр дүнд нь суурилан сургалт орох, мэдлэг боловсрол олгох, зөвлөгөө чиглэл өгөх хүрээнд зохицуулагч байгууллага ажиллах юм. Комплайнсын эрсдэлийн үнэлгээний асуулга нь 4 төрлийн эрсдэл, 10 бүлэг, 42 багц асуулт, 93 дэд асуултуудаас бүрдэх ба бүлэг тус бүрийн агуулгын тайлбар, мэдээлэл цуглуулсны дараа хүрэх үр дүнгийн ерөнхий тайлбар, дүгнэлтийг доор тоймлон боловсрууллаа. Асуулгын 10 бүлэг бүр дэх 42 ерөнхий асуулгын удирдамж болон асуулт бүрд хариулт өгөхдөө анхаарах зүйлсийг дэлгэрүүлэн хавсралт 2-т харуулав.

- Асуулгын хариуг Хуулийн этгээдийн (ХЭ) түвшинд авах шаардлагатай.

- Санхүүгийн байгууллагын салбар, бизнесийн нэгж нь ижил түвшний стандарт бүхий харилцагчийн суурь бааз, бүтээгдэхүүн, хяналтын загвартай байна.
- Энэхүү асуулгыг ХЭ бие даан бөглөж хүргүүлнэ. FCCQ-ийн асуулт бүрийг ХЭ болон түүний бүх салбар бизнесийн нэгж бүрийн нэрийн өмнөөс төлөөлөн бөглөнө.
- Хэрэв ХЭ-ийн хариулт нь салбар бизнесийн нэгжийн аль нэгний хувьд ялгаатай байна гэж үзэх юм бол тодруулга хийх бөгөөд тодруулгын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дэд хэсэг бүрийн төгсгөл хэсэгт тусгах шаардлагатай болно.
- Салбар бизнесийн нэгжийн үйл ажиллагаа (үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, харилцагчийн суурь бааз гэх мэт) нь төв байгууллагаас тодорхой ялгаа бий хэмээн үзэх юм бол тухайн салбар бизнесийн нэгж нь тусдаа асуулга бөглөж болно.

Асуулгын хариулт тус бүрийг сонгох болон тайлбар бичих, хариулт өгөх байдлаар бөглөх ба хэрэв сонгох бол шкал бүхий 5 сонголтоос зааварчилгааны дагуу 1 хувилбарыг сонгоно, харин хариулт бичих бол дэлгэрэнгүй мэдээлэл болон тайлбарыг бичиж үлдээнэ.

Нэгдүгээр бүлэгт 10 асуулт бүхий байгууллагын тухай үндсэн мэдээллийг харуулах ба өмчийн хэлбэр бүтцийн талаар дэлгэрэнгүй асуулга авч хариулт тус бүрээс шаардлагатай үнэлгээ хийж тодорхойлоход оршино. Үүнд санхүүгийн төлбөр тооцоо, харилцах данс болон бусад үйлчилгээ авах хуулийн этгээдийн хуулийн дагуу улсын бүртгэлийн албан ёсны нэр, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй байршил, өмчлөх хэлбэр болон хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай. Хэрэв салбар, бизнесийн нэгж өөр улсад байгаа бол мөн дээрх мэдээллүүдийг дэлгэрэнгүй бөглөнө. Хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг дэлгэрэнгүй авах шаардлагатай. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа болон сэжигтэй, зөрчилтэй мэдээлэл, хууль цагдаагийн байгууллагаас ирсэн прокурорын тодорхойлолт улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх сөрөг мэдээллүүдтэй харилцагчийн мэдээллийг тулган шалгах суурь чадамж мэдлэг ур чадвар, техник хангамжтай ажиллаж буй эсэхийг тодорхойлно. Хувьцаа эзэмшигчид нь улс төрийн нөлөө бүхий этгээд, түүний хамаатан бусад эрсдэлтэй харилцагчдыг таньж мэдэх чадамжтай эсэхийг үнэлнэ.

1. Ёс зүйн эрсдэл

Ёс зүйн эрсдэлийг тодорхойлох хэсгийг оруулсан бөгөөд бизнесийн ёс зүй ба нийгмийн хариуцлага, аудит ба залилан гэсэн дэд хэсгүүдэд авч үзлээ.

- Бизнесийн ёс зүй ба нийгмийн хариуцлага бүлэгт ерөнхий 5 асуулт, 14 дэд асуултуудаар компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, бизнесийн ёс зүй ба нийгмийн хариуцлагын эрсдэлийг үнэлэхэд оршино. Шүгэл үлэх бодлого, сэжигтэй гүйлгээний тайлан боловсруулдаг, улс төрийн нөлөө бүхий этгээдэд бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, дотоод комплайнсын бодлого дүрэм журамтай байх хэрэгтэй.
- Аудит ба залилан бүлэгт 5 ерөнхий асуулт бүхий аудитын үйл ажиллагааг үнэлж дүгнэх болно. Үүнд байгууллагад төрийн хянагч/зохицуулагчдын хяналт шалгалтаас гадна байгууллагын эрсдэлийн үнэлгээ, МУТС, хээл хахууль авлига,

залилан мэхлэлт болон хориг арга хэмжээний бодлого, үйл ажиллагааг тогтмол үнэлдэг дотоод аудит тогтолцоотой байх хэрэгтэй. Энэ бүлгийн асуултаар аудит хяналт шалгалт байгаа эсэхийг тодорхойлж, эрсдэлээ тасралтгүй үнэлж байгаа эсэхийг тодорхойлно.

2. Нэр хүндийн эрсдэл

Нэр хүндийн эрсдэлийг тодорхойлох хэсгийг оруулсан бөгөөд хээл, хахууль авлига, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа гэсэн дэд хэсгүүдэд авч үзлээ.

- 3 ерөнхий асуулт бүхий хээл хахууль ба авлигатай тэмцэх хүрээнд ямар үр дүнтэй дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа талаар үнэлж дүгнэх болно. Үүнд байгууллага дотоод аудитын чиг үүрэгтэй эсвэл бусад бие даасан гуравдагч талаас үйлчилгээ авч хяналтаа тасралтгүй хийх хэрэгтэй. Тасралтгүй сургалтуудыг өөрийн ажилтан эсвэл гэрээт ажилтандаа орох, хамруулах үүрэг хүлээнэ. Гуравдугаар бүлгийн асуулгаар байгууллага хээл хахууль, авлигатай холбоотой үйл ажиллагаандаа дам болон бие даан оролцохоос урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллах мэдлэг ур чадвар байгаа эсэхийг тодорхойлох болно. Ажилтан, мэргэжилтний мэдлэг, ур чадвар сургалтуудыг үнэлж дүгнэхэд оршино.
- 10 ерөнхий асуулт бүхий харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж байгааг үнэлж дүгнэх болно. Үүнд байгууллага харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, дахин хянах техник чадвар, сэжигтэй хэмээн үзсэн тохиолдолд өргөтгөсөн хэлбэрээр харилцагчийг шалгах хянах үнэлдэг байх шаардлагатай. Харилцагчийн талаар бүрэн мэдээлэл цуглуулах, албан бичиг баримт баталгаат гарын үзэг, тулган баталгаажуулалт хийх шаардлагатай байна. Хориг арга хэмжээнд бүртгэгдсэн салбар байгууллага, харилцагч нарт үйлчилгээ үзүүлэхгүй байх хэрэгтэй. Харилцагчийг таньж мэдэх техник, программ хангамжтай эсэх дотоод бодлого дүрэм журмаараа улс төрийн нөлөө бүхий этгээд хамааралтай оролцогч талуудыг таньж мэдэх мэдлэг ур чадвар байгаа эсэхийг тодорхойлно. Харилцагчийн мэдээллийг тулган баталгаажуулах бүртгэл мэдээллийн сан байгаа эсэх тодорхойлно. Харилцагчийг эрсдэлээр нь ангилах, үнэлж буй эсэхийг тодорхойлно.

3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлох хэсгийг оруулсан бөгөөд МУТС, хориг арга хэмжээ, бодлого дүрэм журам, МУТС ба хориг арга хэмжээний хөтөлбөр, хориг арга хэмжээ гэсэн дэд хэсгүүдэд авч үзлээ.

- 6 ерөнхий асуулт бүхий МУТС, хориг арга хэмжээ, бодлого дүрэм журмын боловсруулалт хэрэгжилтийн түвшин ямар байгааг үнэлж дүгнэх болно. Үүнд мөнгө угаалтын эсрэг терроризм санхүүжүүлэхтэй тэмцэх хориг арга хэмжээний зөрчлийн эсрэг ажиллах мэдээллийн сан бүртгэл архивын журам байх хэрэгтэй. Олон улсын хориг арга хэмжээ болон зохицуулагч байгууллагын шаардлага хангаагүй харилцагчдад санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхгүй байх

шаардлагатай. Улс төрийн нөлөө бүхий этгээд тэдний холбоо хамаарал бүхий оролцогч талуудад үйлчилгээ үзүүлэх данс нээхээс татгалзах бодлого дүрэм журам хэрэгтэй. Дөрөвдүгээр бүлгийн асуулгаар байгууллага МУТС, хориг арга хэмжээ авах дотоод бодлого дүрэм журам байгаа эсэхийг тодорхойлох болно. Байгууллага нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн хэрэг бүртгэл мэдээлэл хадгалах журамтай эсэхийг тодорхойлно. Хориг арга хэмжээнд орсон харилцагчдад бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх эрсдэлээс сэргийлэх бодлого, хөтөлбөр хэрэгжүүлдэг эсэхийг тодорхойлно.

- Байгууллагын дотоод хөтөлбөр, хяналтын дүрэм журмыг зохицуулагч байгууллагын шаардлагад нийцүүлэн боловсруулан хэрэгжүүлж чадаж байгаа эсэхийг үнэлж тодорхойлох болно. Байгууллагын комплайнсын эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж, мэргэшсэн туршлагатай ажилтан байгаа эсэх сэжигтэй төлбөр тооцоо, харилцагчийг таньж мэдэж хэрэгжүүлж байгаа эсэхийг тодорхойлж үнэлэх болно. 4 ерөнхий асуулт бүхий МУТС ба хориг арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулж, хэрхэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй талаар дэлгэрэнгүй асуулга авч хариулт тус бүрээс шаардлагатай үнэлгээ хийж тодорхойлоход оршино. Үүнд туршлага/мэргэжлийн ур чадвар бүхий ажилтан байх, мэдээллийн сэжигтэй болон зөрүүтэй байдалд шинжилгээ хийх, эцсийн өмчлөгчийг тогтоох, программ хангамжтай байх, дотоод хяналттай байх хэрэгтэй.
- 4 ерөнхий асуулт бүхий хориг арга хэмжээний талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааг үнэлж дүгнэх болно. Үүнд байгууллагад хориг арга хэмжээний тухай хууль, журам, тэр дундаа гадаадын санхүүгийн байгууллага болон бизнесийн талаар удирдлагаас баталсан хориг арга хэмжээний бодлого дүрэм журамтай байх хориг тавьсан үеийн эсрэг харилцагчийн талаар мэдээллийг цуглуулж шалгадаг байх хэрэгтэй. Хориг арга хэмжээг шалгахад ашигладаг хориг арга хэмжээний олон улсын байгууллагын дагаж мөрдөх шаардлагуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Энэ бүлгийн асуулгаар байгууллага олон улсын хориг арга хэмжээний хөтөлбөрийг дагаж мөрдөж үйл ажиллагаанд авч хэрэгжүүлж байгаа эсэхийг тодорхойлно. Харилцагчийн мэдээллийн жагсаалт үүсгэж шалгах сан баазтай эсэхийг тодорхойлно.

4. Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох хэсгийг оруулсан бөгөөд хяналт, тайлагнал, төлбөрийн ил тод байдал, сургалт ба мэдлэг, боловсрол гэсэн дэд хэсгүүдэд авч үзлээ.

- 4 ерөнхий асуулт бүхий хяналт тайлан хүргүүлэх үйл ажиллагааг үнэлж дүгнэх болно. Үүнд Сэжигтэй үйл ажиллагааг хянах, сэжигтэй гүйлгээг мэдээлэх зохицуулалттай байх, сэжигтэй гүйлгээг тайлагнах бодлого, журамтай байх хэрэгтэй. Энэ бүлгийн асуулгаар байгууллагын сэжигтэй гүйлгээг хянах тайлагнах, мэдээлэх бодлого дүрэм журам байгаа эсэхийг тодорхойлох болно.
- 2 ерөнхий асуулт бүхий төлбөрийн ил тод байдал ямар түвшинд байгааг үнэлж дүгнэх болно. Үүнд сэжигтэй үйл ажиллагааг хянах, сэжигтэй гүйлгээг мэдээлэх зохицуулалттай байх, сэжигтэй гүйлгээг тайлагнах бодлого, журамтай байх

хэрэгтэй. Энэ бүлгийн асуулгаар байгууллагын сэжигтэй гүйлгээг хянах тайлагнах, мэдээлэх бодлого дүрэм журам байгаа эсэхийг тодорхойлох болно.

- 2 ерөнхий асуулт бүхий сургалт ба мэдлэг боловсрол олгох үйл ажиллагаа ямар түвшинд байгааг үнэлж дүгнэх болно. Үүнд, байгууллага мэдлэг боловсрол, ур чадвар хөгжүүлэх тасралтгүй сургалтуудад хөрөнгө оруулалт хийх, ажилтан, гэрээт зөвлөх бэлтгэн эрсдэлийг удирдах шаардлагатай байдаг. Энэ бүлгийн асуулгаар байгууллагын сургалтын үйл ажиллагаа ажилтан зөвлөх мэргэжилтнүүдэд бэлдэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдал ямар байгааг тодорхойлох болно.

Комплайнсын эрсдэлийг тодорхойлох 10 бүлэг, 42 ерөнхий асуултуудад хариулсан байдлаар эрсдэлийн ерөнхий 4 төрлийг тодорхойлно. Үүнд:

Хүснэгт 0.4 Эрсдэлийн төрөл

Д/д	Эрсдэлийн ерөнхий төрөл	Эрсдэлийн хувилбарууд (асуумжийн бүлгээр)
1	Ёс зүйн эрсдэл	Бизнесийн ёс зүй, нийгмийн хариуцлага Аудит ба залилан
2	Нэр хүндийн эрсдэл	Хээл, хахууль ба авлига Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа
3	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл	МУТС, хориг арга хэмжээ, бодлого, дүрэм МУТС ба хориг арга хэмжээний хөтөлбөр Хориг арга хэмжээ
4	Үйл ажиллагааны эрсдэл	Хяналт, тайлагнал Төлбөрийн ил тод байдал Сургалт ба мэдлэг боловсрол

4.2.2 Комплайнсын эрсдэлийн үнэлгээний арга зүй

Дээрх асуумжийн дагуу СЗХ-ноос өөрийн зохицуулалтад байх байгууллага бүрээс асуулгыг тодорхой хугацааны давтамжтайгаар авах бөгөөд асуулгын үр дүнд суурилан тухайн санхүүгийн зуучлагч байгууллага комплайнсын эрсдэлийн өөрийн үнэлгээ хийхээс гадна, зохицуулагч байгууллага комплайнсын эрсдэлийн хөндлөнгийн үнэлгээ хийж, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой болно.

Комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийх арга зүйг онолын хэсэгт авч үзсэн *Compliance Engineering International* байгууллагын санал болгож буй арга зүйд тулгуурлан, “The Wolfsberg Group” санхүүгийн байгууллагын комплайнсын эрсдэлийг тодорхойлох 10 бүлэг, 42 багц, 93 асуулт бүхий асуумжийн загварын дагуу хорооны зохицуулалт дахь байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн боловсруулав. Эдгээр асуумж нь комплайнсын хүрээнд зайлшгүй байх, дагаж мөрдөх, хэрэгжүүлэх хэм хэмжээ, хүчин зүйлсийн хүрээг багтаасан бөгөөд СЗХ-ны зохицуулалт дахь байгууллагуудад чиглүүлэг болно.

Комплайнсын эрсдэлийн үнэлгээний загварын танилцуулга
Хэсэг нэг. Байгууллагын комплайнсын эрсдэлийн өөрийн үнэлгээ

Асуумж: “The Wolfsberg Group” санхүүгийн байгууллагын комплайнсын эрсдэлийг тодорхойлох 4 төрлийн эрсдэлээр 10 бүлэг, 42 багц, 93 асуулт бүхий асуумжийн 42 багц асуултаар эрсдэлийн үндсэн хувилбаруудыг “Асуумж” баганад оруулна уу.
Асуумжид хариулах: Wolfsberg группийн санхүүгийн байгууллагын комплайнсын эрсдэлийг асуумжийн хариултын сонголтот 5 хувилбараас тухайн байгууллага өөрийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх байдлаар сонголтлоо хийнэ.
Үр нөлөө: 93 асуулт бүхий асуумжийн байгууллага өөрийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлсэн үнэлгээнд тулгуурлан, эрсдэлийн тохиолдол бий болсон үед байгууллагад үзүүлэх нөлөөлөл, гарз хохирлыг 1-5 оноогоор үнэлнэ. (Тайлбар: Энд комплайнсын зарчим, стандартыг дагаж мөрдөөгүйн улмаас үүсэх үр нөлөөг авч үзэх юм.)
Хэсэг хоёр. Байгууллагын комплайнсын эрсдэлийн нэгдсэн үнэлгээ
Магадлал: Тухайн байгууллагын асуултад хариулсан сонголтлоос хамаарч эрсдэлийн магадлалыг 1-5 оноогоор үнэлэн харуулна. Магадлалын оноо асуултын хариултаас хамааран автоматаар өгөгдөнө. (Тайлбар: Энд одоо байгаа нөхцөл байдалд үүсэх магадлалыг авч үзэх юм.)
Эрсдэлийн өөрийн үнэлгээ: Энэ хэсэг нь уламжлалт болон суурь эрсдэлийн магадлал, үр нөлөөний 1-5 оноогоор үнэлсэн үнэлгээнд тулгуурлан автоматаар тооцоологдоно. Эрсдэлийн өөрийн үнэлгээнээс хамааран асуулт, бүлэг, эрсдэлийн төрөл тус бүрээр эрсдэлийг 4 түвшинд ангилан, ногоон, шар, улбар шар, улаан өнгөөр ялган харуулна. (Эксэлийн Result_1 шийтийг харна уу.)
Хэсэг гурав. Байгууллагын комплайнсын эрсдэлийн үнэлгээний матриц
Байгууллагын комплайнсын эрсдэлийн өөрийн үнэлгээний үр дүн: Энэ хэсэгт Result_1 шийт дээр үнэлэгдсэн эрсдэлүүдээ Бизнесийн ёс зүй, нийгмийн хариуцлага, Аудит ба залилан, Хээл, хахууль ба авлига, Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа ба бүтээгдэхүүн үйлчилгээ, МУТС ба хориг арга хэмжээ, болдогын баримт бичиг, дүрэм, журам, МУТС ба хориг арга хэмжээний хөтөлбөр, Хориг арга хэмжээ, Хяналт, тайлагнал, Төлбөрийн ил тод байдал, Сургалт ба мэдлэг боловсрол гэсэн 10 бүлэг тус бүрээр эрсдэлийн магадлал, үр нөлөөний үнэлгээгээр матриц дээр байршина. (Эксэлийн Result_2 шийтийг харна уу.)
Эрсдэлийн төрлөөр үнэлгээний үр дүн: Энэ хэсэгт Result_1 шийт дээр үнэлэгдсэн эрсдэлүүдээ Ёс зүйн, Нэр хүндийн, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, Үйл ажиллагааны гэсэн эрсдэлүүд эрсдэлийн магадлал, үр нөлөөний үнэлгээгээр матриц дээр байршина. (Эксэлийн Result_2 шийтийг харна уу.)
Үр дүн: Эксел файлын Байгууллагын өөрийн үнэлгээ шийтийн баруун дээд буланд байрших ҮР ДҮН товч дээр дарахад Result_1, Result_2 шийтүүд ил болж үр дүнгээ харах боломжтой. Үр дүнгээ харахын тулд нууц үг оруулна.
Үр дүн хаах: Эксел файлын Result_2 шийтийн баруун дээд буланд байрших ҮР ДҮН ХААХ товч дээр дарахад Result_1, Result_2 шийтүүд ил харагдахгүй болно.

Хорооны зохицуулалтад байгаа байгууллагуудад Хавсралт 3-т харуулсан “Байгууллагын комплайнсын эрсдэлийн үнэлгээ” экселийн файлыг илгээж, “Байгууллагын эрсдэлийн өөрийн үнэлгээ” нэртэй шийтийг байгууллага бүрээр бөглүүлэн, тодорхой хугацааны дараа хүлээн авснаар комплайнсын эрсдэлийн үнэлгээний мэдээллийг хороо авах боломжтой болно.

Хэсэг нэг. “Байгууллагын комплайнсын эрсдэлийн өөрийн үнэлгээ”

Байгууллага энэ үнэлгээг хийхдээ эксел файлын зааварчилгааны дагуу “The Wolfsberg Group” санхүүгийн байгууллагын комплайнсын эрсдэлийг тодорхойлох 10 бүлэг, 42 багц, 93 асуулт бүхий асуумжид 5 сонголтот хувилбартай хариултуудаас өөрийн байгууллагад тохирохыг сонгоно. Асуулт бүрийн онцлогоос хамаарч, хариултын 5 хувилбар ялгаатай бөгөөд оновчтой 1 хувилбарыг сонгох боломжтой байдлаар асуумж бэлтгэгдсэн. 42 багц асуултуудын зарим хэсэг нь нарийвчилсан байдлаар дэд асуултуудаас бүрдэх бөгөөд дэд асуултууд нэгтгэгдэж 1 багц хариулт, хэд хэдэн багц хариултууд нэгтгэгдэж 1 бүлгийн үнэлгээ хийгдэх байдлаар 42 багц, 10 бүлэг, 4 төрлөөр

эрсдэл үнэлэгдэнэ. Багц асуултууд болон бүлгийн үнэлгээг нэгтгэх томьёог холбож оруулсан тул байгууллагын хувьд үнэлгээг нэгтгэж гаргах шаардлагагүйг анхаарна уу.

“Байгууллагын өөрийн үнэлгээ” хэсэгт комплайнсын эрсдэлийн үр нөлөө үнэлэхдээ асуулт бүрийн хувьд тухайн үзүүлэлт хангалтгүй, бүрэн хийгддэггүй, бүрэн тусгагдаагүй, огт байхгүй тохиолдолд танай байгууллагад ямар хор, хохирол учруулахуйц нөлөөтэй болохыг 1-5 хүртэл оноогоор (1- маш багаас, 5- маш их үр нөлөөтэй) хэмжиж, үнэлнэ. Үр нөлөөний үнэлгээ хийх шалгуурыг жишиг болгож харууллаа. Үр нөлөөний шалгуурын дагуу үнэлгээ өгөхдөө хамгийн хялбар байдлаар тухайн асуулт буюу асуудлын хувьд хэдэн үзүүлэлтэд үр нөлөө үзүүлнэ гэж тодорхойлноос хамааран ижил хувиар үнэлгээг жилэн тооцох боломжтой.

Хүснэгт 0.5 Комплайнсын эрсдэлийн үр нөлөөний шалгуур

Түвшин	5	4	3	2	1
Үзүүлэлтүүд	Маш их	Их	Дунд зэрэг	Бага	Маш бага
Нэр хүнд	Улс, дэлхийн хэмжээнд сөрөг мэдээлэл цацагдах, зах зээлд эзлэх хувийн жин 51-ээс дээш хувиар буурах	Улс, дэлхийн хэмжээнд сөрөг мэдээлэл цацагдах, зах зээлд эзлэх хувийн жин 41-50 хувь буурах	Улс, дэлхийн хэмжээнд сөрөг мэдээлэл цацагдах, зах зээлд эзлэх хувийн жин 31-40 хувь буурах	Улс, дэлхийн хэмжээнд сөрөг мэдээлэл цацагдах, зах зээлд эзлэх хувийн жин 21-30 хувь буурах	Улс, дэлхийн хэмжээнд сөрөг мэдээлэл цацагдах, зах зээлд эзлэх хувийн жин 0-20 хувь буурах
Хөндлөнгийн хяналт, шалгалт	Хөндлөнгийн хяналт шалгалтаар, хууль эрх зүйн болон стандартын шаардлага хангахгүй байгаагаас үйл ажиллагааг бүрэн зогсоход хүргэх	Хөндлөнгийн хяналт шалгалтаар, хууль эрх зүйн болон стандартын шаардлага хангахгүй байгаагаас мөнгөн торгууль тавигдах, үйл ажиллагааг бүрэн зогсоход хүргэх	Хөндлөнгийн хяналт шалгалтаар, хууль эрх зүйн болон стандартын шаардлага хангахгүй байгаагаас албан шаардлага тавигдах, хөндлөнгийн хяналт шалгалтын давтамж нэмэгдэх	Хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил нь үйл ажиллагаанд нөлөөлөхөөргүй, зөвлөмж өгөгдөх	Хөндлөнгийн хяналт шалгалтаар нэг нэгжийг хамарсан стандартын бага хэмжээний зөрчил гарах
Үйл ажиллагаа	Байгууллагын хэмжээнд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг бүрэн алдахад хүрэх	Байгууллагын хэмжээнд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн алдахад хүрэх	Байгууллагын салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг бүрэн алдахад хүрэх	Байгууллагын салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн алдахад хүрэх	Үйл ажиллагааны тасалдал гарахааргүй
Хууль эрх зүйн нийцэл	Хууль, гэрээ, хөрөнгийн биржийн шаардлагын хэд хэдэн удаагийн ноцтой зөрчил нь компанийн дампуурах, хөрөнгийн биржийн бүртгэлээс хасуулахад хүргэх	Хууль, гэрээ, хөрөнгийн биржийн шаардлагын хэд хэдэн удаагийн томоохон зөрчил нь компанийн эсрэг хэрэг үүсгэх, мөрдөн шалгах, шүүхийн нэхэмжлэлд буруутгайд тооцогдох, стандарт, тохирлын гэрчилгээгээ алдахад хүргэх	Хууль, гэрээний нэг удаагийн томоохон зөрчил нь шүүхийн нэхэмжлэлд хүргэх, хөрөнгийн биржийн шаардлагын зөрчил нь хувьцааны арилжааг зогсооход хүргэх	Хууль, гэрээний багахан хэмжээний зөрчил нь шүүхийн нэхэмжлэлд хүргэх, хөрөнгийн биржийн шаардлагын бага хэмжээний зөрчил, засах тухай албан даалгавар авах	Хууль, гэрээ, хөрөнгийн биржийн шаардлагын нэг буюу хэд хэдэн удаагийн жижиг зөрчил

Хэсэг хоёр. “Байгууллагын комплайнсын эрсдэлийн нэгдсэн үнэлгээ”

Хороо өөрийн зохицуулалтад байгаа байгууллага бүрээр Хавсралт 4-т харуулсан загварын дагуу эксел файл үүсгэж, “Байгууллагын комплайнсын эрсдэлийн өөрийн

үнэлгээ” шийт дээр бөглөж ирүүлсэн мэдээлэл нь **“Байгууллагын комплайнсын эрдэлийн нэгдсэн үнэлгээ”** шийт дээр татагдаж, тухайн шийт дэх байгууллагын өөрийн үнэлгээ хэсгийн “С” багана дахь хариултын хэсэг, “D” багана дахь эрдэлийн үр нөлөөний үнэлгээ хийгдсэний дараа “С” баганад байгууллага хариулт дээр ямар сонголт хийснээс хамааран “E” баганад эрдэлийн магадлалын үнэлгээ автоматаар хийгдэх ба комплайнсын эрдэлийн асуултад “Байдаг”, “Бүрэн”, “Тусгадаг”, “Хангалттай” гэх мэт хариултыг өгсөн бол эрдэлийн тохиолдох магадлалыг “Бараг тохиолдохгүй” буюу 1 оноогоор үнэлж, “Oгт байдаггүй”, “Муу”, “Тусгадаггүй”, “Oгт үгүй” гэх мэт хариултыг өгсөн бол эрдэлийн тохиолдох магадлалыг “Тохиолдох магадлал өндөр” буюу 5 оноогоор үнэлэхээр тохиргоо хийж, томъёоллыг оруулсан болно. Эрдэлийн магадлалын хэсгийн үнэлгээ хийгдсэний үндсэн дээр байгууллагын комплайнсын эрдэлийн өөрийн үнэлгээ асуулт тус бүрээр хийгдэж, “F” баганад 1-25 оноогоор үнэлэгдсэн эрдэлийн жагсаалт харагдана. “F” баганад томъёо оруулсан тул тооцооллын хувьд гар ажиллагаа шаардахгүй.

Тус судалгааны ажлын 4.1 хэсэгт авч үзсэн аргачлалын дагуу эрдэлийг магадлал, үр нөлөөний 1-5 оноогоор доор харуулсан эрдэлийн 25-тай матрицан үнэлгээгээр оноожуулан үнэлнэ. Эрдэлийн матрицыг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 0.6 Эрдэлийн матриц

Эрдэлийн үнэлгээ		Магадлалын үнэлгээ				
		1. Маш бага	2. Бага	3. Дунд	4. Их	5. Маш их
Үр нөлөөний үнэлгээ	1. Маш бага	1 - Бага	2 - Бага	3 - Бага	4 - Бага	5 - Дунд
	2. Бага	2 - Бага	4 - Бага	6 - Дунд	8 - Дунд	10 - Их
	3. Дунд	3 - Бага	6 - Дунд	9 - Дунд	12 - Их	15 - Их
	4. Их	4 - Бага	8 - Дунд	12 - Их	16 - Их	20 - Маш их
	5. Маш их	5 - Дунд	10 - Их	15 - Их	20 - Маш их	25 - Маш их

Асуумжийн дагуу 95 асуулт тус бүрээр матриц дахь үнэлгээ гарахаас гадна, 43 багц асуулт, 8 бүлэг тус бүрээр байгууллагын эрдэлийн өөрийн үнэлгээ дээрх матрицын дагуу 1-25 оноогоор нэгтгэгдэн гарна. Мөн эрдэлийн үнэлгээ “F” баганад харуулсан эрдэлийн түвшингээр ялгагдаж харагдана.

Хүснэгт 0.7 Эрдэлийн түвшин

Эрдэлийн оноо	Эрдэлийн эрэмбэ	Эрдэлийн түвшин
1-4	Бага	Хүлээн зөвшөөрөх
5-9	Дунд	Анхаарал хандуулах
10-16	Их	Ноцгой
20-25	Маш их	Аюултай

“F” баганад байгууллагын эрдэлийн өөрийн үнэлгээ 1-4 оноогоор үнэлэгдсэн бол эрдэлийн эрэмбээр бага буюу хүлээн зөвшөөрөгдөх түвшинд, 5-9 оноогоор үнэлэгдсэн бол эрдэлийн эрэмбээр дунд буюу анхаарал хандуулах түвшинд, 10-16 оноогоор

үнэлэгдсэн бол эрдэлийн эрэмбээр их буюу ноцтой түвшинд, 20-25 оноогоор үнэлэгдсэн бол эрдэлийн эрэмбээр маш их буюу аюултай түвшинд тус тус үнэлэгдсэн гэж үзнэ.

Асуумжийн дагуу 95 асуултууд нэгтгэгдэж, 43 багц асуултын үнэлгээ хийгдэх бөгөөд асуултуудыг нэгтгэж, 1 багц асуултын үнэлгээг гаргахдаа асуулт бүр ижил хувийн жинтэй байхаар тооцооллыг оруулав. Мөн бүлгээр эрдэлийн үнэлгээг нэгтгэхдээ багц асуулт бүр ижил хувийн жинтэй байх зарчмыг баримталсан болно. Багц асуулт бүрийн задаргаа асуултын тооноос хамааран 1 шкалын завсрын утга ялгаатай байхаар тооцооллыг хийв.

Багц асуулт болон бүлгээр үнэлгээг нэгтгэхдээ асуулт бүр дээр хамгийн багадаа 1 оноо, хамгийн ихдээ 5 оноо авах боломжтой тул асуултын тооноос хамааруулан хамгийн багадаа асуултын тоотой тэнцүү, хамгийн ихдээ асуултын тоог 5-аар үржүүлж нийт авах боломжтой оноо гарна. Үүнийг 5 шкалд оруулахдаа хамгийн их авах боломжтой онооноос хамгийн бага авах боломжтой оноог хасаж, асуултын тоонд хуваах замаар завсрын утгыг тооцоолж гаргав. Жишээ болгон хүснэгт 4.8-д 11-р асуулт, хүснэгт 4.9-д бүлгийн, хүснэгт 4.10-д эрдэлийн төрлөөр нэгтгэсэн үнэлгээг хэрхэн хийсэн тооцооллыг харуулав.

Хүснэгт 0.8 Асуултын нэгтгэл хийсэн тооцоолол

11-р асуултын нэгтгэсэн үнэлгээ (11a-11f)	Асуултыг нэгтгэж эрдэлийн үнэлгээ хийхдээ 5 шкал үүсгэж, 1 шкалд 4.8 завсрын утгатай байхаар тооцоолов. 11-р асуултын хүрээнд 6 асуулт байгаа тул үнэлгээ хамгийн багадаа 6 оноо, хамгийн ихдээ 30 оноо авах боломжтой байдлаар онооны хязгаараа тогтоож, 5 шкалд ижил хувийн жингээр оноож, 1 шкалд завсрын утга $4.8 \left(\frac{30-6}{5} \right) = 4.8$ байхаар тооцооллоо.
1	6 - 11
2	12 - 16
3	17 - 20
4	21 - 25
5	26 - 30

Асуулт 24 (6 асуулттай, 4.8 завсрын утгатай), асуулт 25 (5 асуулттай, 4 завсрын утгатай), асуулт 30 (17 асуулттай, 13.6 завсрын утгатай), асуулт 32 (3 асуулттай, 2.4 завсрын утгатай), асуулт 33 (5 асуулттай, 4 завсрын утгатай) болно.

Хүснэгт 0.9 Бүлгийн нэгтгэл хийсэн тооцоолол

2.1-р бүлгийн нэгтгэсэн үнэлгээ (10-14 багц асуулт)	Бүлгийн багц асуултуудыг нэгтгэж эрдэлийн үнэлгээ хийхдээ 5 шкал үүсгэж, 1 шкалд 4 завсрын утгатай байхаар тооцоолов. 2.1-р бүлгийн хүрээнд 5 багц асуулт байгаа тул үнэлгээ хамгийн багадаа 5 оноо, хамгийн ихдээ 25 оноо авах боломжтой байдлаар онооны хязгаараа тогтоож, 5 шкалд ижил хувийн жингээр оноож, 1 шкалд завсрын утга ойролцоогоор $4 \left(\frac{25-5}{5} \right) = 4$ байхаар тооцооллоо.
1	5 - 9
2	10 - 13

Бүлэг 2.2 (4 багц асуулттай, 3.2 завсрын утгатай), бүлэг 3.1 (3 багц асуулттай, 2.4 завсрын утгатай), бүлэг 3.2

3	14 - 17	(9 багц асуулттай, 7.2 завсрын утгатай), бүлэг 4.1 (6 багц асуулттай, 4.8 завсрын утгатай), бүлэг 4.2 (3 багц асуулттай, 2.4 завсрын утгатай), бүлэг 4.3 (4 багц асуулттай, 3.2 завсрын утгатай), бүлэг 5.1 (4 багц асуулттай, 3.2 завсрын утгатай), бүлэг 5.2 (2 багц асуулттай, 1.6 завсрын утгатай), бүлэг 5.3 (2 багц асуулттай, 1.6 завсрын утгатай) байхаар тооцоолол хийгдсэн болно.
4	18 - 21	
5	22 - 25	

Хүснэгт 0.10 Эрсдэлийн төрлөөр нэгтгэл хийсэн тооцоолол

Ёс зүйн эрсдэлийн нэгтгэсэн үнэлгээ (2.1-2.2 бүлэг)	Ёс зүйн эрсдэлийн багц асуултуудыг нэгтгэж эрсдэлийн үнэлгээ хийхдээ 5 шкал үүсгэж, 1 шкалд 1.6 завсрын утгатай байхаар тооцоолол. Ёс зүйн эрсдэлийн хүрээнд 2 бүлэг асуулт байгаа тул үнэлгээ хамгийн багадаа 2 оноо, хамгийн ихдээ 10 оноо авах боломжтой байдлаар онооны хязгаараа тогтоож, 5 шкалд ижил хувийн жингээр оноож, 1 шкалд завсрын утга ойролцоогоор 1.6 $\left(\frac{10-2}{5}\right)=1.6$ байхаар тооцоолол.
1	2 - 3
2	4 - 5
3	6 - 7
4	8 - 9
5	10

Нэр хүндийн эрсдэл (2 бүлэг, 1.6 завсрын утгатай), МУТС эрсдэл (3 бүлэг, 2.4 завсрын утгатай), үйл ажиллагааны эрсдэл (3 бүлэг, 2.4 завсрын утгатай) байхаар тооцоолол хийгдсэн болно.

Санхүүгийн зохицуулах хороо цаашид эрсдэлд суурилсан хяналтыг авч хэрэгжүүлэх

Энэ хэсэгт хорооны зохицуулалт дахь байгууллага тус бүр дээр комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийгдээд ирсний дараа **“Байгууллагын комплайнсын эрсдэлийн нэгдсэн үнэлгээ”** шийтийн “G”, “H” болон “I” баганад тус тус үнэлгээнүүд хийгдэнэ.

“G” баганад **“Байгууллагын комплайнсын эрсдэлийн өөрийн үнэлгээ”**-ний асуултад хариулсан байдалд тулгуурлан хяналтын зэрэглэлийн үнэлгээ автоматаар хийгдэнэ.

“H” баганад СЗХ зохицуулалтад байгаа байгууллагууддаа Wolfsberg -ийн асуулгын дагуу хяналтын үйл ажиллагааны үр дүнд тулгуурлан тухайн эрсдэл гарах магадлалыг 1-5 шкалын дагуу 1 хариултыг сонгож үнэлгээ өгнө. Ингэснээр “I” баганад үлдэгдэл эрсдэл томьёоллын дагуу бодогдож, үнэлгээ хийгдэнэ.

Байгууллагын комплайнсын эрсдэлийн өөрийн үнэлгээ болон СЗХ-ны комплайнсын эрсдэлийн хяналтын үнэлгээнд үндэслэн хорооны комплайнс хариуцсан мэргэжилтэн байгууллага зөвлөмж хүргүүлэх талбар дээр юун дээр анхаарах, цаашид юу хийх талаар бичгээр зөвлөмж хүргүүлж болно.

Бүлгийн дүгнэлт

- Байгууллагууд эрсдэлээ олж илрүүлэх, тэдгээрийн ач холбогдлыг үнэлэхийн тулд комплайнсын эрсдэлийн үнэлгээг хийх ёстой бөгөөд комплайнсын эрсдэлийн үнэлгээний аргачлал нь эрсдэлийн удирдлага, эрсдэлийн үнэлгээний арга, арга зүйтэй адилхан юм. Комплайнсын эрсдэлийн үнэлгээ нь байгууллагын хууль эрх зүйн болон бизнесийн орчинтой холбоотой бий болж буй эрсдэлийн зураглалыг тодорхойлж, холбогдох эрсдэлийн үзүүлэлтүүдийг жинлэн оноожуулах байдлаар эрсдэлийн үнэлгээг хийдэг. Эрсдэлийн үнэлгээний үр дүнд одоо байгаа эрсдэлийн түвшинд авах арга хэмжээнүүдийг сайжруулж, эрсдэлийг бууруулах үндсэн тогтолцоонд суурилдаг ба тухайн бизнес нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд онцгой анхаарал хандуулдаг.
- Комплайнсын эрсдэлийн удирдлага нь эрсдэлийг шинжлэх, үнэлэх, удирдах, хянах гэсэн тогтолцооны дагуу явах бөгөөд эрсдэлийн үнэлгээг хийх нийтлэг олон аргачлал байдаг ч комплайнсын эрсдэлийн үнэлгээг хийхдээ холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхийг нь тухайн салбарт тохирсон тусгай асуулт, асуумжаар үнэлдэг. Эрсдэлийн үнэлгээг хийхдээ байгууллагын өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн хяналтын дагуу үнэлгээг хийх бөгөөд уламжлалт эрсдэл болон үлдэгдэл эрсдэлийг тодорхойлох байдлаар үнэлгээг хийж, холбогдох дүгнэлт, санал зөвлөмжийг өгдөг байна.
- “The Wolfsberg Group”-ийн 2022 - 2023 оны банк ба санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зуучлагч байгууллагуудад зориулсан “Санхүүгийн гэмт хэрэг комплайнсын асуулга” эх сурвалжаас авч, орчуулан СЗХ-ны зохицуулалтад байгаа байгууллагын комплайнсын ажилтнуудаас авахаар боловсруулав. Ингэхдээ комплайнсын хүрээнд зайлшгүй байх хүчин зүйлсийг багтаасан бөгөөд тухайн байгууллага өнөөдөр төгс байх албагүй, асуултад хамрагдсанаар комплайнсын хувьд ямар асуудалд анхаарах шаардлагатай, ямар хэм хэмжээг дагаж мөрдөх шаардлагатай талаар мэдээлэл өгөх зорилготой.
- Асуулгын үр дүнд суурилан тухайн санхүүгийн зуучлагч байгууллага комплайнсын эрсдэлийн өөрийн үнэлгээ хийхээс гадна, зохицуулагч байгууллага комплайнсын эрсдэлийн хөндлөнгийн үнэлгээ хийж, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой болно.
- Эрсдэлийн үнэлгээг үндсэн 2 хэсгээр хийхээр аргачлалаа тодорхойлсон. Эхний хэсэгт байгууллага комплайнсын эрсдэлийн өөрийн үнэлгээ хийнэ. Хоёр дахь хэсэгт Байгууллагын өөрийн үнэлгээнд тулгуурлан комплайнсын эрсдэлийн нэгдсэн үнэлгээ хийгдэнэ.
- Эрсдэлийн үнэлгээг магадлал болон үр нөлөөний хүчин зүйлээр хийж, тус бүрд нь 1-5 шкалаар үнэлгээ өгч, эрсдэлийн дулааны матриц дээр эрсдэлээ 4 түвшинд ангилан байршуулахаар аргачлалаа боловсруулсан болно.

ДҮГНЭЛТ

- Олон улсад санхүүгийн зохицуулах байгууллагад тулгарч буй чухал асуудлуудын нэг нь комплайнсын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх асуудал байна. Зохицуулах байгууллагын зүгээс холбогдох хууль эрх зүйн актуудыг батлуулах, хэрэгжүүлэх журам, зааврыг боловсруулан мөрдүүлэх, түүний үр дүнг эргэн хянах, тасралтгүй хөгждөг тогтолцоог бүрдүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэх шаардлагатай байна.
- Волтер Клувер олон улсын судалгааны байгууллагаас комплайнсын удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд байгууллагад тулгарч буй 10 гол асуудлыг салбарын экспертүүдээс санал асуулга авах байдлаар тодорхойлсон байна. Үүнд, зохицуулалтын шаардлагыг хангаж буй эсэхээ тодорхойлдог, үр дүнтэй комплайнсын бодлого боловсруулж, хэрэгжүүлдэг, түүнийг дэмжсэн хяналт, үнэлгээ хийдэг, шагнал урамшууллын бодлогоор дэмждэг, комплайнсын соёлыг бүрдүүлж, эрсдэлийг илрүүлэх, үнэлэх процесст автоматжуулалтыг ашиглах зэрэг асуудлууд байна. Ялангуяа засаглал, эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, процесстой комплайнсын удирдлагыг уялдуулах хэрэгтэй.
- Комплайнсын тогтолцоог санхүүгийн байгууллагууд хэрэгжүүлснээр байгууллагын тогтвортой, амжилттай үйл ажиллагаа явуулах суурь нөхцөл бүрдэх ба салбарын хэмжээнд санхүүгийн тогтвортой байдал бүрдэх ач холбогдолтой.
- Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын эрх зүйн орчны талаарх мэдээллийг авч үзэхэд санхүүгийн байгууллагуудын комплайнсын зохицуулалт гэдэгт олон улсын түвшинд банк, зээлийн хоршоо, хөрөнгө оруулалтын сан, даатгалын компани болон бусад санхүүгийн байгууллагууд холбогдох хууль тогтоомж, журам заавар, салбарын стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулахын тулд авч хэрэгжүүлж буй үйл явц, арга хэмжээг авч үзэж байна. Олон улсад нийтлэг, зайлшгүй байх зохицуулалтын хууль, эрх зүйн орчинд хэрэглэгчийн эрхийг хамгаалах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, үйлчлүүлэгчээ таньж мэдэх, мэдээллийн хамгаалалт ба нууцлал, хөрөнгийн хүрэлцээ, эрсдэлийн удирдлага, үнэт цаас, хөрөнгө оруулалтын удирдлага, санхүүгийн тайлагналын стандартыг зохицуулсан хуулиудыг авч үздэг байна.
- Манай улсын хувьд санхүүгийн салбарын комплайнсын зохицуулалтын эрх зүйн орчны судалгаанаас макро түвшинд болон салбарын зайлшгүй байх хуулиуд батлагдан, зохицуулалттай санхүүгийн салбар бүрийн журам, зааврууд үйлчилж байгаа нь эрх зүйн орчин бүрдсэн болохыг харуулж байна. Харин байгууллагын түвшинд комплайнсын нэгж заавал байх ёстойг, комплайнсын бодлого, төсөвтэй зайлшгүй байх шаардлагатайг 2022 оноос Компанийн засаглалын кодекст тусган, дагаж мөрдөж байгаа ба СЗХ-ноос комплайнстай холбоотой суурь ойлголтууд, комплайнсын байгууллага дээрх удирдлагын талаарх сургалтуудыг идэвхтэй явуулж байна.
- СЗХ-ны зохицуулалттай санхүүгийн салбарын комплайнсын тогтолцооны өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор 111 байгууллагаас судалгаа авахад засаглал, комплайнсын тогтолцоо нь эрсдэлийн удирдлагаас илүү сайн бүрдсэн гэж харуулжээ. Комплайнсын тогтолцооны бүрдэл хэсгээр задлан авч үзвэл санхүүгийн гэмт хэрэг, мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог илүү боловсронгуй болгох хэрэгтэй гэж үзжээ.
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад зохицуулалтын шаардлагатай холбоотойгоор комплайнс хариуцсан алба нэгж эсвэл ажилтантай, холбогдох дүрэм журамтай байна гэж заасны дагуу комплайнсын тогтолцоо бусад салбартай харьцуулахад харьцангуй өндөр буюу 70 гаруй хувьд нь бүрджээ.
- Комплайнсын удирдлагын хөтөлбөр, төлөвлөгөөг нийт байгууллагуудын тал хувь нь боловсруулж, хэрэгжүүлдэг ба санхүүгийн болон хүний нөөцийн дутагдал үүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд гол бэрхшээл болдог гэж дүгнэсэн байна.
- Судалгаанд хамрагдсан байгууллагуудын дийлэнх хэсэг нь ТУЗ-ийн түвшинд комплайнсын асуудлыг хэлэлцэж, ач холбогдол өгдөг ба комплайнсын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, хяналт шалгалт хийх арга зүйгээ сайжруулах чиглэлд дэмжлэг авах хүсэлтэй байгааг судалгааны үр дүн харуулж байна.
- Комплайнсын эрсдэлийн удирдлага нь эрсдэлийг шинжлэх, үнэлэх, удирдах, хянах гэсэн тогтолцооны дагуу явах бөгөөд эрсдэлийн үнэлгээг хийх нийтлэг олон аргачлал байдаг ч комплайнсын эрсдэлийн үнэлгээг хийхдээ холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхийг нь тухайн салбарт тохирсон тусгай асуулт, асуумжаар үнэлдэг. Эрсдэлийн үнэлгээг хийхдээ байгууллагын өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн хяналтын дагуу үнэлгээг хийх бөгөөд уламжлалт эрсдэл болон үлдэгдэл эрсдэлийг тодорхойлох байдлаар үнэлгээг хийж, холбогдох дүгнэлт, санал зөвлөмжийг өгдөг байна.
- Комплайнсын эрсдэлийн үнэлгээ нь байгууллагын хууль эрх зүйн болон бизнесийн орчинтой холбоотой бий болж буй эрсдэлийн зураглалыг тодорхойлж, холбогдох эрсдэлийн үзүүлэлтүүдийг жинлэн оноожуулах байдлаар эрсдэлийн үнэлгээг хийдэг. Эрсдэлийн үнэлгээний үр дүнд одоо байгаа эрсдэлийн түвшинд авах арга хэмжээнүүдийг сайжруулж, эрсдэлийг бууруулах үндсэн тогтолцоонд суурилдаг ба тухайн бизнес нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд онцгой анхаарал хандуулдаг.
- “The Wolfsberg Group”-ийн 2022-2023 оны банк ба санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зуучлагч байгууллагуудад зориулсан “Санхүүгийн гэмт хэрэг комплайнсын асуулга” эх сурвалжаас авч, орчуулан СЗХ-ны зохицуулалтад байгаа байгууллагын комплайнсын ажилтнуудаас авахаар боловсруулав. Ингэхдээ комплайнсын хүрээнд зайлшгүй байх хүчин зүйлсийг багтаасан бөгөөд тухайн байгууллага өнөөдөр төгс байх албагүй, асуулгад хамрагдсанаар комплайнсын хувьд ямар асуудалд анхаарах шаардлагатай, ямар хэм хэмжээг дагаж мөрдөх шаардлагатай талаар мэдээлэл өгөх зорилготой.
- Асуулгын үр дүнд суурилан тухайн санхүүгийн зуучлагч байгууллага комплайнсын эрсдэлийн өөрийн үнэлгээ хийхээс гадна, зохицуулагч байгууллага комплайнсын эрсдэлийн хөндлөнгийн үнэлгээ хийж, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой болно.
- Эрсдэлийн үнэлгээг үндсэн 2 хэсгээр хийхээр аргачлалаа тодорхойлсон. Эхний хэсэгт байгууллага комплайнсын эрсдэлийн өөрийн үнэлгээ хийнэ. Хоёр дахь хэсэгт Байгууллагын өөрийн үнэлгээнд тулгуурлан комплайнсын эрсдэлийн нэгдсэн үнэлгээ хийгдэнэ.
- Эрсдэлийн үнэлгээг магадлал болон үр нөлөөний хүчин зүйлээр хийж, тус бүрд нь 1-5 шкалаар үнэлгээ өгч, эрсдэлийн дулааны матриц дээр эрсдэлээ 4 түвшинд ангилан байршуулж, анхаарал хандуулах эрсдэлүүдэд тодорхойлох боломжийг олгож байгаа нь тухайн аргачлалын давуу тал болно.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

СЗХ-ны зүгээс комплайнсын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зохицуулалтын үйл ажиллагааны хүрээнд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

- Засаглал, эрсдэл болон комплайнсын удирдлагыг уялдаа холбоог хангасан зохицуулалтын шаардлага тавих;
- Байгууллага нь өөрийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, хүний болон санхүүгийн нөөцөд суурилсан, тасралтгүй сайжирдаг, тайлагнадаг тогтолцоог бүрдүүлэх шаардлага тавих, үр дүнг тогтмол хянадаг байх;
- Комплайнсын эрсдэлийн талаарх нэгдсэн ойлголтыг зохицуулалтын салбарын бүхий л байгууллагад нэг жигд хүргэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг болох гарын авлага боловсруулах, шаардлагатай тохиолдолд сургалт, хэлэлцүүлэг, зөвлөх үйлчилгээг санал болгодог байх;
- Комплайнсын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх жишиг аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Комплайнсын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, үр дүнг хянах бүхий процесст техник, технологийн дэвшлийг хэрэгжүүлснээр эрсдэл буурах, бүтээмж нэмэгдэх, зардал хэмнэгдэх зэрэг олон давуу талыг бий болгох боломжтой;
- Комплайнсын тогтолцоог бүрдүүлэхэд шаардлагатай зохицуулалтын шаардлагыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болсон заавар, гарын авлагыг боловсруулах;
- Санхүүгийн салбар дах комплайнсын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор энэ чиглэлийн сургалт, таниулах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;
- Байгууллагад комплайнсын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, үр дүнг хянах жишиг тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг болох ажлуудыг зохион байгуулах, зохицуулалтын шаардлагад тусгах;
- Комплайнсын удирдлагыг хэрэгжүүлэхэд ашиглах болох технологийн оновчтой шийдлийг олох, хөрөнгө оруулалтын зардлыг бууруулахын тулд хамтарсан судалгаа хийх, оновчтой технологийн шийдлийг олох, мэдээллийг аюулгүй байдлыг хангах зэрэг арга хэмжээг авах;

Хууль эрх зүйн орчныг сайжруулах, боловсронгуй болгох чиглэлд

